МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

mminfo.mn Шударга, Шуурхай, Өнцгөй мэдээлэл

# МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Хүн ам 3,089,187... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.06.16. Пүрэв. №122 (4492) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

## МОНГОЛ АРДЫН НАМ ХАНДИВЫН ДАСНАА НЭЭЛЭЭ

“ХААН БАНК” 5115028001 тоот данс

**Иргэн та хандив өргөхдөө**
Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу:
50.1.1 Иргэн гурван сая төгрөг хүртэл /регистерийн дугаар/
50.1.2 Хуулийн этгээд арван сая төгрөг хүртэл /регистерийн дугаар/

**Сонгуулийн тухай хуулийн 40.3-д:**
...“Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийн банкинд нээлгэсэн, сонгуулийн зардлын дансанд энэ хуульд заасан журмын дагуу төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулна” гэсэн, заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дансыг нээсэн тул намын гишүүд, дэмжигчид, дэмжигч байгууллага, иргэд та бүхнийг хандив өргөхийг хүсье.

Дугаарын 60 мөр

## Ухаалаг 00-той болъё

Б.ДАВАА

Манай улсад аялж буй жуулчдын хамгийн их хүсдэг зүйл бол энэ. Хүний хэрэглээний юм бүхэн ухаалагжиж, боловсронгуй болж буй өнөөгийн нийгэмд ганц л зүйл хөгжөөгүй өнөөдрийг хүрсэн нь хөдөө орон нутаг явах зам зуурт таарах хоолны газар, амралтын газруудын жорлон гэдэгтэй хэн ч маргахгүй. Монголбанк, Аялал жуулчлалын төвөөс өнгөрсөн онд манай улсад аялсан жуулчдын зардлын түүвэр судалгааг гаргасан байдаг. Түүвэр судалгааны хүрээнд 2015 оны долдугаар сарын 6-13-ний өдрүүдэд Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал, Улаанбаатар төмөр замын буудлаас Монгол Улсад аялаад буцаж буй 1233 жуулчнаас анкетын аргаар мэдээлэл цуглуулж, судалгаа авчээ. Улмаар судалгаанд оролцсон жуулчдын Монгол Улсад аялсан шалтгаан, сэтгэл ханамжийг дүгнэхэд дийлэнхи буюу 76 хувь нь Монголын уламжлалт зан заншил, соёл болон үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтанд татагдан хүрэлцэн ирсэн гэдгээ хэлж, дахин ирнэ гэдгээ илэрхийлсэн байх аж.

**Үргэлжлэл нь II нүүрт**

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## БОНДООР БҮТЭЭСЭН БАЯЛГАА ҮЙЛДВЭРЛЭГЧИД СУРТАЛЧЛАВ

–Чингис бондоос санхүүжсэн 129 аж ахуйн нэгж төв талбайд үзэсгэлэн гаргалаа–

Б.ӨНӨРТОГТОХ

Өчигдөр төв талбай хүн ихтэй өнжив. Их эзэн Чингис хааны талбай дүүрэн эгнүүлэн барьсан цагаан асар болгоны үүдэнд иргэд хөл тавих зайгүй багширч “Нионшэль” компанийн 250 төгрөгийн өндөг, “Эксклюсив” компанийн 9000 төгрөгийн зуны нимгэн цамц, пудволк, “Говь” компанийн ноолууран ороолт, “Дашваанжил” компанийн эгдүүтэй зургаар чимэглэсэн хогийн сав, хүүхэддээ үлгэрийн ном, эхнэртээ MR брэндийн цүнх худалдаж авахаар очер дараалал үүсгэж байлаа. Ёстой л дэгсдүүлж хэлсэн хүнд ногоон хурганы арьс, нохойн битүү туурайнаас бусад бүх л барааг хямд үнээр худалдаалж байх аж. Нөгөө талаар төв талбайд ажил хэргийн уулзалт ч болох нь олон тааралдана. Манай хуванцар хаалга, цонхны бэлдэцийн давуу тал нь ийм байна. Тиймээс төрийн санхүүжилтээр баригдаж буй барилгад бүтээгдэхүүнээ нийлүүлэх хүсэлтэй байна. Манай компанийн ажилчдын хувцас, өмсгөлийг оёж нийлүүлэх хүсэл байгаа бол манайхтай ирж уулзаарай хэмээн асраас асарт ажил хэрэгч яриа, худалдан авалт, хамтарч ажиллах гэрээ хэлцэл хийгдэж байсан юм.

**Үргэлжлэл нь III нүүрт**

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**




чухал ХҮН



## Хассуурийн ГАНХУЯГ: МОНГОЛД ХОЁР ТОМ “ХАВДАР” БАЙГААГИЙН НЭГ НЬ МАНАН

Дэлгэрэнгүй IV-V нүүрнээс

## ХОНГ КОНГ РУУ НИСЛЭГ ҮЙЛДЭЭД 5 ЖИЛ БОЛЖЭЭ

60 ANNIVERSARY

Үндэсний Агаарын Тээвэрлэгч МИАТ ТӨХК өнөөдрөөс яг 5 жилийн өмнө Хонг Конг хот руу тогтмол шууд нислэг анх үйлдэж эхэлсэн билээ. МИАТ ТӨХК энэ хугацаанд 833 нислэг үйлдэж 208,749 зорчигч, 826 тонн ачаа тээвэрлэжээ. Өнөөдөр МИАТ компани Хонг Конг хот руу долоо хоногт 5 удаа буюу даваа, мягмар, пүрэв, баасан, ням гарагуудад нислэг үйлдэж байна.

Дашрамд дурдахад зорчигчдын тээшний журмыг шинэчлэн ширхэгийн системд шилжээд байна. Ингэснээр зорчигчод энгийн ангилалаар аялсан тохиолдолд 23кг НЭГ ширхэг, бизнес ангилалаар аялсан тохиолдолд 32кг НЭГ ширхэг тээш үнэгүй тээвэрлэх боломжтой боллоо.




МОНГОЛЫН МЭДЭЭ 18 дахь жилдээ

## Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд 44 дугаар

захиалгын үнэ 15400

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1958.00 | 1972.00 | ФУНТ | 2734.00 | 2816.00 |
| ЕВРО | 2177.00 | 2230.00 | РУБЛЬ | 28.00 | 31.70 |
| ИЕН | 18.25 | 18.71 | ЮАНЬ | 296.00 | 299.00 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1962.00 | 1975.00 | ФУНТ | 2742.00 | 2810.00 |
| ЕВРО | 2174.00 | 2233.00 | РУБЛЬ | 28.82 | 31.27 |
| ИЕН | 18.27 | 18.81 | ЮАНЬ | 296.30 | 300.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

## УЛС ТӨР

ФЕЛЬЕТОН

# БАГГҮЙ БАТ-ҮҮЛ БАГАДАНА

(ганц Бат–Үүл ганцдана)
















Б.ЦЭНДДОО

### Нэг. Гитлер хүүгийн явдал

Ийм яриа явж байна гэнэ. Явах ч юу байхав, явуулж байгаа юм байна. “Бат-Үүлийгээ сонгож хотын дарга болгочихоод бусдыг МАН-даа өгье” гэж.

За тэгээд өнөө нэг үлгэр шиг юм болох нь л дээ. Дэлхийн хоёрдугаар дайны үед фронтод бэлэг цуглуулж байхад болсон явдал гэж байгаа. Нэгэн хүдэр эр хоёр морь хөтөлж хэдэн хонь тууж ирээд “Ялж яваа баатарлаг улаан армид хоёр морь бэлэглэе. Харин тэр хэдэн хонийг ялагдаж, зүдэрч яваа хөөрхий Гитлер хүүд өгөх юм шүү” гэсэн гэдэг.

Харин шинэ цагийн Гитлер хүүгийн үлгэрээр бол нийслэлийн иргэд хотоо удирдан хөгжүүлж чадна гэдэгт нь итгэсэн нэг саналаа Бат-Үүлд өгөөд, үлдсэн 44 суудлыг нь “хөөрхий ялагдаж зүдэрч яваа МАН хүүд” өгөх юм байна. Дүнд нь АН нэг л суудалтай үлдэж, МАН үнэмлэхүй ялах учиртай ажгуу.

Хуучин арга ч биш л дээ. 2000 онд Архангай нутагтаа алдар хүндийн оройдоо явсан нэр дэвшигч Р.Гончигдоржийг яг тийм аргаар унагасан юм. Тэр үед МАХН-ынхан (Одоогийн МАН чинь тийм нэртэй байсан) “Нутгийн ах дүүс минь энэ Гончигдоржийгоо гамнаж байгаад хойтон ерөнхийлөгч болгох нь дээр гэж бид тохироод байгаа” хэмээн сурталчилсаар байгаад унагачихаж билээ.

МАН-ын пиар сайн. Тэд бүтэн зууны туршлагатай бөгөөд биднийг хүссэн болгондоо үнэмшүүлж, Чингис хааны хүртэл үндэстний дайсан гэж итгүүлж чадсан үзэл сурталчид. Хэлсэн болгонд нь үнэмшдэг иргэд бүхий нийгмийг бүтээж чадсан улс гэхээр үнэхээр л аюумаар, биширмээр.

Харин өнөөдөр нийгэм нээлттэй болж ард түмэн итгэх, үл итгэх эрхтэй болсон нь “Гитлер хүүг”-ийн үлгэрийг шүүмжлэн хэлэлцэх боломж олгож байна.

### Хоёр. Ганц Бат–Үүл ганцдана

Хэрвээ нийслэлд АН ялагдвал бид Бат-Үүлгүй болно. Үнэн хэрэгтээ ганц Бат-Үүл хэн ч биш. Юун хотын хүчирхэг удирдагч вэ, харин хурал дээр ганцаараа үглэсэн цагаан өвгөн л болно. Ийшээ тиишээ хий янцгааж давхисан, адуугүй ганц азарга л үлдэнэ. Учир нь түүнийг сүргийн манлайгаараа томилдог сүрэг адууг нь та бид сонгоогүй учраас тэр.

Манайхны зарим нь ерөнхийлөгчийг бүх ард түмэн сонгодог, харин Их хурлын гишүүнийг тойрог тойргоос сонгодог тогтолцоотай андуураад байна. Андуурах юу байхав, андуурууллаад байна.

Олон түмээн, битгий ингэж андуур. Ард түмнийг андуу байгаасай, яг л 1990 оноос өмнөх үеийнх шигээ андууруулахад амархан байгаасай хэмээн мөрөөддөг улсын бахыг битгий ханга. Үл андуурагч, Үнэн учрыг ологч болж тэднийг сөр.

Үнэн хэрэгтээ хотын депутатууд хуралдаад сонгодог Нийслэл хотын дарга, Их хурлаас хамааралгүйгээр бүх ард түмнээс сонгогддог ерөнхийлөгч хоёр шал тусдаа.

Хотын иргэдийн хуралд ялсан нам л хотын даргаа сонгодог. Хэрвээ МАН ялбал Бат-Үүлийн барааг дахиж харахгүй. МАН ялчихсан атлаа, ялагдсан намын даргыг хотын удирдагчаар томилно гэж байх уу. Хотын дарга байтугай, хэлтсийн дарга ч хийлгэхгүй. Ухаандаа, 1945 онд Германыг ялсан Сталин бээр ялагдсан “хөөрхий Гитлер”-ийг үнэлэн үзэж Зөвлөлтийн удирдлагад оруулах байсан гэвэл үнэмших хүн гарах уу?

Бат-Үүл та нарт хэрэгтэй байгаа бол Бат-Үүлийн намыг л сонго. Бат-Үүлийн нам нь АН шүү. (Цаадуул чинь “Бат-Үүл бол манай МАН-ны дарга байгаа юм гэж хээв нэг залах улс шүү, мэдээтэй байгаарай).

Нийслэлд АН ялбал л Бат-Үүл ялна. Ахиад хотоо хөгжүүлнэ. Та АН-д дургүй байж болно, гэхдээ төрөлх хотдоо хайртай, нийслэлдээ сайхан амьдрах дуртай биз дээ. Хэрвээ тийм бол үзэн ядалтаа март, дургүйцлээ тэвч, би ч бас тэвчье, тэгэх үү?

Илүү сайхан юмны төлөө тэвчиж болох муухай юм гэж байдаг юм.

mminfo.mn
Шударга, Шуурхай, Өнгийн мэдээлэл

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
88873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Дугаарын 60 мөр

## Ухаалаг ОО-той болъё

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэгвэл эсрэгээр аялал жуулчлалын үйлчилгээг илүү сайжруулахын тулд юу хийх шаардлагатай вэ гэсэн асуултад судалгаанд оролцсон жуулчид дуу нэгтэйгээр угаалгын өрөө, жорлонгийн асуудлыг нэрлэсэн байх юм. Өнгөрсөн оны судалгаа ийм байна. Харин яг одоо аялал жуулчлалын улирал эхэлж буй энэ үед жуулчид хүлээн авахад бэлэн үү гэсэн асуултыг салбарт ажиллаж буй шат шатны аж ахуй нэгжээс асуумаар байна. Аялал жуулчлалын салбар аль ч улс орны эдийн засгийн чухал салбарын нэг байх учиртай. Тиймээс ч төр засгийн хэмжээнд жуулчдын тоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа нь сайшаалтай. Гэхдээ 21-р зууны монголчууд “Хол замд явахад нүхэн жорлон ч байдаггүй”, “Зам зуур дахь хоолны газруудынх нь нүхэн жорлон нь дүүрчихсэн бие засахын аргагүй өмхий үнэртэй”, “Монголчууд ийм жорлонг яаж ашигладаг юм бол” гэх зэргээр гадны жуулчдад чичлүүлсээр байх нь ичгэвтэр зүйл биш гэжүү. Арга ядсан орчуулагчид нь дэмий л маасайн инээвхийлэх ийм дүр зураг хэдий болтол үргэлжлэх вэ. Нэгэн жишээ дурьдая. Өнгөрсөн жил зуны амралтаараа гурав хоногийн хугацаатай морин аялалд оролцов. Монгол хэл, ёс заншлыг 20 гаруй жил суралцсан нэгэн япон эрийн аялалын багт багтаж Төв аймгийн нутгаар мориор аялсан хэрэг. Хөтөч нь өөрөө япон хүн болохоор ч тэр үү, надтай хамт аялсан хүмүүс бүгд л японы жуулчид байсан юм. Төв аймгийн Аргалант гэх нэртэй газраас эхэлсэн аялал минь Элсэн тасархай, Хустайн нуруугаар дамжиж, Улаанбаатар хүртэл морины нуруун дээр л өнгөрсөн. Харин замдаа буудаллах үед нөгөө жуулчдаасаа маш ихээр ичиж билээ. Хээр буудаллах үеийг яалтай билээ гэж бодоход, Элсэн тасархайд бол харин нүүр хийх газаргүй болдог юм байна. Баруун аймгууд руу явах хүмүүс энд буудаллаж хоол иддэг учраас хүний хөл ч тасрахгүй шинжтэй. Гэсэн ч хоёр, гурван цаг морин дээр сэгсчүүлсэн хэсэг жуулчид боловсон жорлон хайгаад олсонгүй. Олсон ганц нүхэн жорлон нь гишгүүр хүртлээ өтгөнөөр дүүрчихсэн байхыг хараад үнэндээ санаа зовсон гэж жигтэйхэн. Нөгөө жуулчид ч хамраа дарж, хээр газар бараадсан нь дээр бололтой гэх нь тэр. Ер нь манайхан мөнгө нэхэж мэдэхээс үйлчилгээндээ, бүр ОО-доо анхаарах нь ховор юм билээ. Ганц энэ жишээ ч биш. Дархан хот явах замд “Урьхан” гээд хоолны газар бий. Боловсон ОО-той үйлчилгээ нь ч дажгүй гэж үнэлэгддэг тэр газар суултуураа том хүн 1000, хүүхэд 500 төгрөгөөр үнэлж байх юм. Энэ бол зөвхөн манайд л байх дүр зураг. Дэлхийн хаана ч үйлчилгээний байгууллага үйлчлүүлэгчиддээ ОО-ын суултуураа үнэлж, мөнгө нэхдэггүй юм билээ. Жуулчдын Монголоос жийрхэх цөөхөн шалтгааны нэг нь энэ. Гэхдээ үүнийг шийдэх гарц бий. Эрүүл мэнд, спортын яам дөрвөн төрлийн нүхэн жорлонгийн стандартыг баталж гаргасан байдаг. Уг стандарт өнгөрөгч хоёрдугаар сараас эхлэн мөрдөгдөж эхэлсэн. Тиймээс төвийн цэвэр, бохир усны шугамд холбогдох боломжгүй хөдөө орон нутгийн үйлчилгээний газрууд дээрх стандартын жорлонг ч болов нэвтрүүлэх хэрэгтэй байна. “Чингис хаан”-ы төрсөн нутаг гэдгээрээ дэлхийд нэрээ тамгалсан манай улсад жуулчдыг татах олон зүйл бий. Байгалийн үзэсгэлэнт газрууд, Монголын уламжлалт ахуй, морин аялалаас эхлээд уламжлалт соёлыг харуулсан урлаг соёлын наадмууд тэдний Монголд дахин ирэх шалтгаан болдог юм билээ. Харин үйлчилгээ тэг хувийг заах аж ахуй нэгжээс үүдээд жуулчдаа үргээсээр байх уу. Энэ жил ирсэн 200, 300 мянган жуулчдыг бүгдийнх нь биш юм аа гэхэд 90 хувийг нь сэтгэл хангалуун буцаахад эргээд манай улс руу “ноён ногоон”-ыг барьсан эрхмүүд мянга мянгаараа цувах нь гарцаагүй.

## УИХ-ЫН ГИШҮҮН Л.ЭРДЭНЭЧИМЭГ ЁС ЗҮЙН АЛДАА ГАРГАСАНДАА УУЧЛАЛТ ХҮСЛЭЭ




Б.ДАВААХҮҮ

УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэгийн албан өрөөндөө тамхи татаж, вино шимэн сууж байгаа бичлэг цахим ертөнцөөр тараад байгаа билээ. Энэ бичлэгийг Сонгинохайрхан дүүргийн 71, 72 дугаар тойрогт өрсөлдөж байгаа “Иргэдийн шударга шүүх” ТББ-ын тэргүүн Х.Бат-Ялалт, сэтгүүлч Т.Алтаншагай нар дэлгэсэн байдаг. Тэд хэвлэлийн хурал хийж, Л.Эрдэнэчимэг гишүүн уг бичлэгээ худалдаж авахын тулд 50 сая төгрөгийн хахууль өгсөн мэтээр ярьсан юм. Харин Л.Эрдэнэчимэг гишүүний хувьд бичлэгийг үзээгүй хэмээж, үзсэнийхээ дараа хариу тайлбар хийнэ гэдгээ амлаад байсан. Тэгвэл амласан ёсоор өчигдөр “Монгол Ньюс” мэдээллийн төвд хэвлэлийн хурал хийж, үүсээд буй нөхцөл байдлын талаар тайлбар хийллээ. Тэрбээр “2016 оны зургадугаар сарын 6-ны өдөр Х.Бат-Ялалт надтай ирж уулзсан. Улмаар тус бичлэгийг үзүүлээд 200 сая төгрөгөөр зарна гэж хэлсэн. Би бичлэгийг үзээд миний төрсөн өдрөөр Г.Уянга гишүүн тоглоом шоглоом маягаар гар утас дээрээ бичиж байсан бичлэг мөн болохыг мэдсэн. Тэгээд Г.Уянга гишүүний гар утас дээрх бичлэг чухам яагаад өөрийнх нь гарт орсныг Г.Уянга гишүүнээс асууж, хуулийн байгууллагад хандаж асуудлыг шалгуулна гэдгээ хэлсэн. Үүний дараа Г.Уянга гишүүнтэй ярьсан. Г.Уянга гишүүн гар утсаа хулгайд алдсан гэдгээ хэлж, энэ асуудлаар Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст хандсан байгаа гэдгээ учирласан. Намайг ч бас цагдаагийн байгууллагад хандахыг зөвлөсөн. 2016 оны зургадугаар сарын 7-ны өдөр би ЧД-ийн цагдаагийн хэлтэст очиж, Х.Бат-Ялалт хулгайд алдсан утас дээрх бичлэгийг үзүүлж, 200 сая төгрөг нэхсэн талаар гомдол гаргасан байгаа. Энэ хэрэг одоо цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа. Миний гаргасан гомдлын дагуу Х.Бат-Ялалт мэдүүлэг өгсөн байх учиртай. Г.Уянга гишүүний утсыг яаж хулгайлж авсан талаараа мэдүүлсэн байх гэж бодож байна. Үүнээс хойш долоо хоногийн турш Х.Бат-Ялалт надаас мөнгө нэхэж байна.

Сүүлдээ сонгуулийн дараа өгье, түр мөнгө зээлээч гэсэн. Тиймээс би 50 сая төгрөгийг өөрийн нэр дээрээс зээл гэж шилжүүлсэн. Баримт нь ч бий. Зээлээ төлөхгүй бол насан туршдаа нэхнэ шүү гэж хэлсэн. Үүнийг насан туршийн зээл гэж өөрөө ярьж байна лээ. Ажлын байран дээр вино ууж, тамхи татаж ес зүйн алдаа гаргасандаа ард түмнээсээ уучлалт гуйж байна. Харин миний хэлсэн үг хүний эрхийн асуудал гэж бодож байгаа. Хууль зөрчсөн үйлдлийнхээ хүрээнд зохих 50 мянган төгрөгний торгуулиа өнөөдөр төлсөн. Цаашид өөр хариуцлага хүлээх ёстой бол түүнийгээ хүлээнэ. Би 1984-1990 онд Болгар улсад сурч байхдаа тамхи татаж сурсан. Өөрөө 20 жил тамхи татаж буй хүний хувьд тамхины хяналтын тухай хуулийг гаргасан. Өөрийнхөө санаачилсан хуулийг зөрчиж буй нь ёсзүйн том алдаа гэж бодож байна” гэсэн юм. Түүнчлэн, Тавантолгойн ажлын хэсгийг ахалж эхэлсэн үеэс байнгын заналхийлэл, сүрдүүлэгт өртөх болсноо Л.Эрдэнэчимэг гишүүн хэвлэлийн хурлын үеэр мэдэгдсэн бөгөөд түүнийг занилхийлж буй бүлэглэлийн гар хөл хэмээн сөргөлдөгчдөө тодорхойлов. Тэрбээр “Тавантолгойн ажлын хэсгийг ахалж ажилласан үеэс хойш нэг жилийн хугацаанд намайг байнга дарамталж, заналхийлж байгаа. Утсаар аятайхан байхгүй бол ална шүү гэж хүртэл байнга заналхийлдэг. Тосон бумбын нурууг хамгаалалтад авах юм бол Ц.Оюунгэрэл та хоёр 50 тэрбум төгрөг төлөөрэй гэж хүртэл заналхийлсэн. Энэ хэргээс болж биологич залуу амиа алдсаныг та бүхэн мэдэж байгаа. Х.Бат-Ялалт, Т.Алтаншагай нар биднийг байнга заналхийлж буй бүлэглэлийн гар хөл нь гэж би ойлгож байна. Тэд уг нь нэр дэвшигчид. Энэ мөчид иргэдтэйгээ уулзалт хийж, мөрийн хөтөлбөрөө танилцуулаадявжбайх учиртай. Би энэ хэргийг нэлээд хэд хоногийн өмнөөс маш нарийн төлөвлөсөн хэрэг гэж бодож байгаа. Т.Алтаншагай 72 дугаар тойрогт надтай яагаад өрсөлдөх болов. Харин Х.Бат-Ялалт намайг 71 дүгээр тойрогт өрсөлдөнө гэж андуураад тойргоо сольж чадалгүй нэрээ дэвшүүлчихсэн байх. Өнгөрсөн жил Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээ батлагдаагүй бол 1072 ширхэг хувьцааны мөнгөжүүлэх үйл явц хийгдэхгүй байсан. Үүний хариуг шат дараатайгаар надаас авч байна гэж хардаж байна. Т.Алтаншагай, Х.Бат-Ялалт нар ямар санхүүжилттэй байгааг хуулийн байгууллага шалгаж, үнэн мөнийг тогтоож өгнө гэдэгт итгэж байна. Х.Бат-Ялалт, Т.Алтаншагай мэтийн шантаажлагчдыг битгий сонгоорой гэж уриалмаар байна” гэсэн юм.

## ҮЗЭЛ БОДОЛ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

# БОНДООР БҮТЭЭСЭН БАЯЛГАА ҮЙЛДВЭРЛЭГЧИД СУРТАЛЧЛАВ




**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Дотоод, гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх, эдийн засгийн хэцүү үед хаалгаа барьчихалгүй ажиллахаас бусдыг бодохгүй ажиллаж зүтгэж байдаг эдгээр бизнес эрхлэгчид бүгд Хөгжлийн банкны санхүүжилт Чингис бондоос зээл авч ажлаа эхлүүлж, бизнесээ өргөжүүлж, технологио шинэчилсэн компаниуд. Тиймээс өчигдөр болсон “Чингис бонд” экспог зорин ирж бүтээж чадсан баялгаа танилцуулсан нь энэ юм. “Монголчууд бүтээж байна” уриатай зохион байгуулсан тус үзэсгэлэнг Засгийн газар, Аж үйлдвэрийн яам, Хөгжлийн банк хамтран зохион байгуулжээ. Өнгөрөгч долоо хоногт “Бондоор санхүүжсэн бүтээн байгуулалт” хэлэлцүүлэг зохион байгуулж, бондын санхүүжилтийн үр дүнд бий болсон эдийн засгийн үр ашгийг тооцоо судалгаатай хэлэлцсэн бол, өчигдөр энэ бонд хэрхэн бодит ажил болсныг иргэд аж ахуйн нэгж, компаниудын үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнээс харж чадлаа. УИХ-ын 52 дугаар тогтоолоор босгосон Чингис бондын мөнгө дэлхийн зах зээлд зэс, алт, нүүрсний үнэ унасан хэцүү үед дотоодын зах зээлээ хамгаалах, эдийн засгаа эрүүлээр авч үлдэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Үзэсгэлэнд “Чингис” бондоос санхүүжилт авсан 129 аж ахуй нэгж, байгууллагууд оролцож, төслийн үр дүнг танилцууллаа. Мөн “Домог” хамтлаг талбай дүүрэн цугласан иргэдэд тоглолтоо сонирхуулсан юм. Энэ үеэр Авто замын төсөл, “Гудамж” төсөл, Инженерийн дэд бүтцийн төсөл, ДЦС-4 хүчин чадал нэмэгдүүлэх, Таван толгойн цахилгаан станц, Эгийн голын усан цахилгаан станц зэрэг томоохон төслүүдийг танилцуулж, аж ахуйн нэгжүүд өөрийн бүтээгдэхүүнээ иргэдэд танилцуулахаас гадна нээлттэй худалдаалав.

## Ч.Сайханбилэг: Хэрэглээг шүтсэн бус хуримтлал үүсгэсэн эдийн засаг бий боллоо

Нээлтийн ёслол 11.45 минутад эхэлж, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мөнхбат, Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Нямхүү нар нээж үг хэллээ. Бондын мөнгө бодит ажил хэрэг болж чадсаныг талархан дэмжсэн хүн бол Ч.Сайханбилэг сайд. Тэрбээр, “Монголчууд бүтээж чадаж байна” уриатай энэхүү үзэсгэлэнг нээж үг хэлэхдээ “Чингис бондын санхүүжилт гурван том зүйлийг бий болгож чадлаа. Нэгдүгээрт, улсаа дэд бүтэцтэй, иргэдээ байртай, компаниудаа ажлын байртай болгож чадлаа. Хоёрдугаарт, Чингис бондын үр дүнд 6.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийх боломж бий болгож, эдийн засагтаа хуримтлал үүсгээд байна. Гуравдугаарт, хэрэглээг шүтдэг бус хуримтлал үүсгэсэн эдийн засгийн алхмаа хийж чадсан юм. Хөгжлийн банк хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулж, УИХ, Засгийн газраас баталсан хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж байлаа. Өнгөрсөн оны байдлаар 4.9 их наяд төгрөгийн дүн бүхий санхүүжилтийг төсөл хөтөлбөрүүдэд олгоод байна” гэв. Харин Хөгжлийн банкны захирал Н.Мөнхбат “Хөгжлийн банк байгуулагдаад таван жил боллоо. Өнгөрсөн таван жилд хийж бүтээх ажлаа бүрэн хийж чадлаа. Бондын хөрөнгөөр хийж байгаа санхүүжилт бол дотооддоо гаргасан үндэсний хөгжлийн бодлогын дагуу хийгдэж байна. УИХ-ын 11 шийдвэр, Засгийн газрын 100 гаруй тушаалын хүрээнд энэ санхүүжилт явж байна. Бонд ашиг орлого харсан, арилжааны биш урт хугацааны хөгжлийн бодлогыг илүүтэй дэмждэг. Бондын санхүүжилт хоорондоо уялдаатай хийгддэг. Одоогийн байдлаар дэд бүтэц, цахилгаан дулааны эрчим хүч, төрийн орон сууцны барилга зэрэг томоохон улсын хэмжээний төсөлд зарцуулсан” хэмээлээ.

## Х.Майцэцэг: Нүдээ олсон хөрөнгө оруулалтын өгөөж эргээд ард түмэнд ирдэг

Хөгжлийн банкны олгосон санхүүжилтийг ангилж үзвэл авто зам, дэд бүтцийн салбар 1.39 их наяд, “Эрдэнэс Тавантолгой” шинэ төмөр зам, ТОСК, Иргэний нисэх, Амгалан дулааны станц, ТЭЦ III, IV станцуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Нүүрснээс синтетик хий үйлдвэрлэх төсөл зэрэг том хэмжээний улсын төсөлд 1.95 их наяд, цементийн үйлдвэр, төмөр зам, барилга ноос ноолуур, оёдол, арьс шир зэрэг хувийн хэвшлийн төслүүдэд нийтдээ 1.56 их наяд төгрөгийг тус тус зарцуулжээ. Хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн бондын хөрөнгө оруулалт “Шинэ төмөр зам”, “Тавантолгой” зэрэг том хэмжээний улсын төслөөс гадна импортыг орлох, экспортыг дэмжих ЖДҮ-ийн төслүүдийг дэмжихэд чиглэжээ. Манай сурвалжлах хэсэг талбай дүүрэн эгнүүлсэн цагаан асарт байрлах аж ахуйн нэгжүүдээс “Шинэ төмөр зам”, худалдан авагч хамгийн ихтэй байсан “Эксклюсив”, 20 гаруй жил үйл ажиллагаа явуулж буй “Үлэмж чанар” сургалтын төв, экспортод бүтээгдэхүүнээ гаргаж эхэлсэн “Эко ноос” компани, дотоодын зах зээлд цоо шинэ технологиор хивс үйлдвэрлэж эхэлсэн Эрдэнэт хивсний үйлдвэр, Итали улсын орчин үеийн технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж буй “Нионшэль” өндөгний үйлдвэр, цонх, хаалганы хуванцар бэлдэц үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлж буй “Бейерпластикс” компани, Алтан Урлан, Монэнзи зэрэг компаниудыг онцолж уншигч танд танилцуулъя. “Эксклюсив” компани ноос ноолуурын салбарт олгосон санхүүжилтээс хамгийн ихийг буюу 750 сая төгрөгийн санхүүжилтийг 2013 оны аравдугаар сард Чингис бондоос авчээ. Тус компанийн захирал Х.Майцэцэг “Манай компани 2009 онд Монголын анхны оёмол хувцасны үйлдвэр болон үйл ажиллагаагаа явуулсан. Чингис бондоос 750 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт авсан. Нүдээ олсон хөрөнгө оруулалтын үр дүн эргээд ард түмэндээ ирдэг гэдэг. Манай орон сүүлийн 26 жил хэрэглэгч орон байсан бол өнөөдөр оёмол бүтээгдэхүүнийг өөрсдөө үйлдвэрлэж байна” хэмээлээ. Тус компани худалдаалж буй цамц, өмдөндөө “Чингис бондын үр өгөөж” гэсэн бичиг хадаж, зах зээлийн үнээс хэд дахин хямд буюу цамцаа 5-10, өмдөө 15 мянган төгрөгөөр зарлаа. “Чингис” бондын санхүүжилтийн хүрээнд “Эрдэнэт” компани үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө шинэчилжээ. Бельги улсын Азидаа ганцхан байдаг тоног төхөөрөмжийг тус компани оруулж ирснээр хивсэн бүтээгдэхүүн нь зөвхөн дотооддоо биш олон улсын тавцанд өрсөлдөх боломж бүрдсэн аж. Энэхүү технологи метр квадратад нэг сая утас нэхдэг гэдгээрээ зөвхөн Монголдоо хамгийн өндөр нягтралтай хивс үйлдвэрлэх боломжийг бүрдүүлсэн гэнэ. Чингис бондоос санхүүжилт авснаар өмнө нь хоёр ээлжээр 800 гаруй ажилтантай ажиллаж байсан бол одоо гурван ээлжээр 1100 гаруй ажилтантай ажиллаж байгаа гэв. Бүтээгдэхүүний 54 хувь нь дотооддоо, 46 хувь нь экспортод гардаг. Одоогоор 10 гаруй оронд бүтээгдэхүүнээ экспортолж байгааг тус компанийн маркетинг хариуцсан мэргэжилтэн бидэнд танилцуулав. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжсэн Чингис бондын талаар үйлдвэрлэгчид санал бодлоо хуваалцсаныг уншигч танд хүргэе.






## Л.Гантөмөр: Үндэсний үйлдвэрлэгчдэд давуу эрх хэрэгтэй байна



*/“Гэр өрөг” компанийн захирал/*

-“Бейерпластикс” компани дотоодын зах зээлд цонх хаалганы хуванцар бэлдэц нийлүүлдэг. 2004 онд анх байгуулагдсан. Үйлдвэрлэлийн хоёр шугамтай. 2014 онд бид Чингис бондоос тэрбум 300 сая төгрөгийн зээл авсан. Налайхад 3000 м/кв үйлдвэрлэлийн барилгатай, үйлдвэрлэлийн найман шугамтай үйлдвэрийг 2015 онд ашиглалтад оруулаа. Цогц хэлбэртэй үйлдвэрлэл байна гэсэн зорилго тавьсан. Үйлдвэрийн байрнаас гадна сав баглаа боодлын склад, мөн ажилчдын цайны газар, амралтын өрөө баригдах юм. Жилдээ 3000 тонн цонх, хаалганы бэлдэц үйлдвэрлэх хүчин чадалтай. Нийт зах зээлийн 40 орчим хувь байх юм. Нөгөө талаар цонхны гурван төрлийн бэлдэцийн систем үйлдвэрлэж байна. Цонхны балконд зориулагдсан бэлдэц үйлдвэрлэж эхэллээ. 12 жил үйл ажиллагаа явуулж буйн хувьд давуу тал гэвэл ажилчид маань бүгд мэргэшсэн. Хоёрдугаарт, барилга зохиомжоо монгол орны нөхцөлд зохицуулж гаргаж чадсан. Манай бүтээгдэхүүн ОХУ-д хэд хэдэн үзэсгэлэнд орж диплом, алтан медалиар шагнуулсан. ОХУ-д бүтээгдэхүүний дээжээ явуулж чанарын сертификат авлаа. Бидний хийж байгаа бүтээгдэхүүн гадны бүтээгдэхүүнээс дутахгүй. “Чингис бонд”-оор олон үйлдвэрүүдийг бий болголоо, мөнгө гаргаад үйлдвэр байгуулж болдог юм байна. Гэхдээ өнөөдөр борлуулалтад төр оролцох хэрэгтэй юм шиг. Яагаад гэвэл, барилгын бүтээн байгуулалт маш их явагдаж байгаа. Үүнд хамгийн гол нь үндэсний үйлдвэрлэлээ орох давуу эрхийг бий болгох хэрэгтэй.

## Т.Дунжаа: Бид баялаг бүтээж байна



*/“Үлэмж чанар” сургалтын төвийн захирал, Монгол Улсын гавьяат багш, зөвлөх инженер/*

-“Үлэмж чанар” сургалтын төв 25 жилийн түүхтэй. Голлож гар хивсний сургалт, судалгаа, үйлдвэрлэл явуулдаг. Гар хивс бол дэлхийн тансаг бүтээгдэхүүнд тооцогддог учраас импортыг орлох, экспортод гарах бүтээгдэхүүн хийх зорилго тавиад ажиллаж байгаа. 2000 онд дэвшилтэд технологи санаачилж, оюуны өмчийн патент авсан. 16 жилийн хугацаанд олон хивсэн бүтээгдэхүүний загвар гаргаж, олон удаагийн үзэсгэлэн худалдаанд оролцож шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, шилдэг технологийн шагналуудыг авсан. Төр засаг үе шаттай дэмжиж байна. Дүүргийн зүгээс ч дэмжлэг их байгаа. Сонгинохайрхан дүүрэг ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж, хөнгөлттэй ажлын байраар хангадаг. Мөн жил бүр тендерт оролцож эрхийн бичгийн сургалт явуулдаг. Эсгий, хивс, гар хийж, сувд шүр, арьсан эдлэлийн урлалын сургалт явуулдаг. Баялаг бүтээгчдийг бид бэлтгэж, мөн өөрсдөө ч баялаг бүтээж байна. Эрхийн бичиг олгох сургалтыг сүүлийн найман жил явуулж байгаа.

## н.Бат–Эрдэнэ: Бондын эргэн төлөлтөө графикийн дагуу хийгээд эхэлчихсэн



*/“Эко ноос” компанийн Гүйцэтгэх захирал/*

-Манайх Чингис бондоос 6.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан. Япон технологи, ноу-хау-гаар барилгын дулаалгын материал хийж байна. Монгол хонины ноосоор хийж байгаа. японд шаардлагатай бүх стандарт нь батлагдаж, долдугаар сараас тус улс руу экспортод гаргахад бэлэн болоод байна. Япон стандартад тэнцэнэ гэдэг маш том шалгуурыг давсан гэсэн үг. Шилэн хөвөн зэрэг барилгын материалын дэргэд экологийн цэвэр бүтээгдэхүүн гэдгээрээ давуу талтай. Бондын эргэн төлөлтийг графикийн дагуу хийгээд эхэлчихнэ. Эскпортод бүтээгдэхүүн гараад эхлэхээр энэ талаар санаа зовох зүйлгүй болно.

## Т.Далантай: Бондын санхүүжилтээр технологио шинэчилсэн



*/“Нионшэль” компанийн захирал /*

-Манай компани 2009 оноос өндөг үйлдвэрлэл, тахианы чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Анх 5000 өндөглөгч тахиатай үйл ажиллагаагаа эхлүүлж, өнөөдрийг хүртэл тасралтгүй ажиллаж байна. Өдгөө 60 мянган өндөглөгч тахиатай үйл ажиллагаа явуулж байгаа. Чингис бондоос бид 2014 онд 640 сая төгрөгийн зээл авч Итали улсын “Тecno” компанийн сүүлийн үеийн дэвшилтэд, бүрэн автомат технологийг Монголд оруулж ирсэн. Европ стандартын Итали технологийг оруулж ирсэн анхдагч компани боллоо. бидний бусдаас ялгарах давуу тал гэвэл Европ стандартын хүнсний зориулалтын тамга, тосоор өндгөө тамгалдаг. Тэжээл нь мөн европынх. Манай өндөгний чанар экологийн цэвэр, төрөл бүрийн амин дэмээр баялаг байдаг. Ер нь борлуулалтыг жаахан дэмжээд өгвөл үндэсний үйлдвэрлэгч шувууны болон өндөгний аж ахуй эрхлэгчид дотоодын хэрэгцээгээ 70 хувийг хангах боломжтой. Эдийн засгийн хямрал бидэнд нөлөөлж байна. Өндөгний үйлдвэр эхлээд санхүүжилт орж, дараа нь ашгаа өгдөг хүнд бизнес. Тиймдээ ч импортын өндөг, тахиан маханд хяналт тавимаар байгаа юм.

## Г.Соёл–Эрдэнэ: Тоног төхөөрөмж, ажлын байраа нэмэгдүүллээ



*/“Монэнзим” компанийн Чанарын хяналтын албаны менежер/*

-Чингис бондоос санхүүжсэнээр эм, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбартаа тоног төхөөрөмж, хүн хүчээ өргөжүүлж чадлаа. Түүхий эдээ бид Солонгос улсаас авдаг. Өмнө нь тасалдах, мөнгө санхүүгийн асуудлаас болж хойшлох зэрэг асуудал гардаг байсан. Тэр асуудлаа шийдэж чадсан. Ажлын байраа нэмэгдүүлж, ээлжийн ажилчидтай боллоо. Манайх тендерт оролцож, бүтээгдэхүүнээ нийлүүлдэг. Монголын эм ханган нийлүүлэх байгууллага болон хөдөө орон нутаг, нийслэлийн бүх эмнэлгүүдийн хэрэглээний 40 хувийг хангаж байгаа. Сардаа 2.5-6 сая тариур, жилдээ 30 сая тариур үйлдвэрлэх хүчин чадалтай. Цаашдаа үйл ажиллагаагаа илүү өргөжүүлэх зорилго тавьсан.

## Д.Энх–Ундраа: Бондоос авсан зээл өгөөжөө өгсөн



*/“Алтан урлан” компанийн захирал/*

-Манайх 2015 онд бондоос зээл авсан. Авсан зээлээрээ 20 гаруй ажлын байр бий болголоо. Ажиллах орчин нөхцлөө сайжруулаа. Үйлчлүүлэгчдийн таашаалд нийцдэг боллоо. өмнө нь тавуулаа л ажилладаг байсан. Зээлд хамрагдсанаар асар их өөрчлөлт гарч чадсан. Зах зээлийн хямрал их байгаа гэж их ярьж байна. Манайх зээлд хамрагдаж чадсанаар энэ бүхнийг ажралгүй давж байгаа. Гадаад зах зээлийг судалж эхэлсэн. Зээл өгөөжөө өгсөн. Зээлийн эргэн төлөлт ч хэвийн явагдана. Өөрийн гэсэн худалдан авагчтай учраас борлуулалт байхгүй тохиолдол ховор. 10 гаруй жил оёдлын салбарт туушталь ажиллачихсан байна.

ЧУХАЛ ХҮН

# Хассуурийн ГАНХУЯГ: МОНГОЛД ХОЁР ТОМ

–Өнгөрсөн 26 жилийн хугацаанд МАНАН–гаас өөр сонголт байхгүй юм шиг явж ирлээ. Энэ удаад ард түмэндээ офшортонгууд нуугдаад, хатуу гишүүнчлэлээр ээлжлэн 26 жил захирч байна. Шинэ хүн, шинэ хүчин гарч ирэх гэхээр

Н.ПУНЦАГБОЛД

*УИХ-ын сонгуулийн 70 дугаар тойрогт бие даан нэр дэвшич байгаа Хассуурийн Ганхуягийг энэ удаагийн "Чухал хүн" буландаа урьж, ярилцлаа*



*Баянгол дүүргийн 15-р хороонд УИХ-ын сонгуулийн 70 дугаар тойрогт бие даан нэр дэвшигч Хассуурийн Ганхуягийн сонгуулийн штаб*

**-Та УИХ-ын сонгуулийн 70 дугаар тойрогт бие даан нэр дэвшч байгаа. Чухам яагаад энэ тойрогт өрсөлдөх болов?**

-70 дугаар тойрог бол нийслэлийн Баянгол дүүргийн зүүн хэсгийг бүхэлд нь хамарсан гэж хэлж болно. Би энд төрж, өссөн. Улс төр гэдэг миний хувьд цоо шинэ зүйл биш. Ажлын шугамаар улсынхаа эдийн засгийн нэгээхэн хэсэг болж хамт олонтойгоо бүтээн байгуулалтад оролцоод явж байхад нийгэм, улс төрийн харилцаа, тогтолцооны гажуудалтай хүссэн хүсээгүй нүүр тулгарч байдаг. Тэгвэл миний энэ удаагийн гаргасан шийдвэр бол миний үр хүүхэд амьдрах нийгмийг ямар байх вэ гэдгийг хөндлөнгөөс харах биш, өөрийн биеэр шийдвэр гаргах төвшинд зүтгэх, гар бие оролцох, хариуцлага санаачилгатай байхыг хүссэн шийдвэр. Цаг хугацааны хувьд бид жинхэнэ хүндээ хүрсэн хөгжилд ирэх үү, ардчилалаа хуурмаг байдалд алдах уу гэдгийг шийдэх цаг үе ирж байна. Тиймээс өөрийнхөө төрж өссөн газартаа л ирэх нь зөв юм байна гэж үзсэн. Ингээд 70 дугаар тойргийг сонгож, бие даан өрсөлдөж байгаа юм. Би Баянгол дүүргийн 19 дүгээр хорооны 61 дүгээр байрны хүүхэд. Нэг ёсондоо, энэ миний өсөж, төрсөн газар. Надтай өрсөлдөж байгаа ихэнх хүмүүс өөр нутгийнх. Хоёр нь гэхэд насаараа Өвөрхангайн төлөөлөл болж явсан. Нутгийнхан нь хүлээж авахаа болихоор түрүүчийн сонгуулиар намын жагсаалтаар парламентад сонгогдсон. Одоо Баянголд ирж байх жишээтэй. Бусдыг нь би энэ дүүрэгт амьдарч байсан эсэхийг нь сайн мэдэхгүй байна. Тэр утгаараа 70 дугаар тойргийг илүү төлөөлж чадна гэж сонгон өрсөлдөж байгаа юм.

**-Та өмнө нь төрөлх дүүргээ, өссөн орчноо иргэн хүний нүдээр харж явсан байх. Тэгвэл энэ тойрогт таны нүдэнд тусч байгаа, нэн түрүүнд шийдэх ёстой ямар асуудлууд байна?**

-Өнгөрсөн нэг, хоёрдугаар сард "Петровис"-оос зохион байгуулан "Монгол хүн Монголын баялаг" гэдэг нэвтрүүлэг хийсэн юм. Энэ нэвтрүүлэгт намайг хөтлөгчөөр оролцохыг санал болгосон. Энэ хугацаанд бид Европын өндөр хөгжилтэй олон улсад очиж, хотуудыг нь үзэж байсан. Хамгийн сүүлд очсон хот бол Санкт-Петербург байсан юм. Тэнд очиход эртний барилгууд хэвээр байна билээ. Харин хотын зах руугаа манай хорооллын барилгууд шиг олон угсармал орон сууцтай байсан. Яг л социализмын үед явж байгаа юм шиг мэдрэмж төрж байлаа. Гэхдээ нэг ялгаа нь хот төлөвлөлт. Манай улсад болохоор орон сууцны дундах хүүхдийн тоглоомын талбай дээр нь барилга барьчихдаг. Явган хүний гарцыг нь таглаад байшин бариад, чигжчихлээ шүү дээ. Гэтэл 1990 оноос өмнө эмх цэгцтэй, төлөвлөлттэй байсан. Хэрвээ яг тэр хэвээр байсан бол байрнууд нь л жаахан хуучрахаас биш хүүхэд эрүүл орчинд өсөхөөс авахуулаад бүх боломж хангагдахаар тийм л байсан. Өнөөдөр иргэдийн бухимдаад байгаа зүйл нь ойлгомжтой биз дээ. Гаднаа хүүхэд тоглох, хөгшид амрах талбайтай байсан бол алга болоод, хүн зөрөх ч зай үлдэхгүй бол яах билээ. Өөрөөр хэлбэл тэнд хот тэлэх маягаар хөгждөг бол манайх нягтрах, түгжрэх маягаар буруу төлөвлөлт зонхилоод байна. Энэ мэтээр хот төлөвлөлт хүмүүсийн амьдрал руу шууд нөлөөлөөд эхэлсэн. Ядаж байхад хот төлөвлөлтийг хот биш дүүрэг нь тусдаа хийдэг болчихсон. Баахан барилга байшин барьчихсан. Үүнээс болоод хүний бүх эрх зөрчигдөж байна. Үндсэн хуулинд иргэдийг олон сайхан эрхтэй гэж заагаад өгчихсөн байдаг биз дээ. Тэр болгоноо зөрччихсөн. Үндсэн хууль зөрчсөн хүнд ногдох хариуцлагын тогтолцоо алга. Иргэдээс нь асуухгүйгээр байшин барьдаг болсон. Одоо бараг сул газар ч алга болчихож. Яахав, тухайн үед хороолол орчимд хамгийн өндөр үнэтэй орон сууц барьдаг байж. Тэр ч утгаараа өндөр боловсролтой, боломжтой хүмүүс нь амьдардаг байсан. Тиймээс хороолол хавьд байшин бариад, аль болохоор өндөр үнээр зарахын тулд хоосон зай болгоныг нь бөглөөд, хүмүүсийнхээ үл хөдлөх хөрөнгийг нь үнэгүйдүүлчихэж. Иймэрхүү л дүр зураг ажиглагдаж байна. Намайг энд амьдарч байх үед бүх зүйл эмх цэгцтэй, орц нь цэвэрхэн, гэрэл гэгээтэй байсан юм. Би айлуудаар өөрөө сонгуулийнхаа материалыг тараагаад явж байгаа. Тэгж явахдаа цөөнгүй айлаар орлоо. Гэтэл орцноос нь 20, 10, 5 жилийн өмнө, өнөөдөр ч ялгаа байхгүй шивтэр үнэртсэн хэвээр. Орцны хаалга кодтой, түгжээтэй л болж. Энэ мэт олон асуудал байна.

Гэр хороололд бол цэцэрлэг, сургуулийн асуудал үнэхээр хүнд. Байгаа хэдхэн цэцэрлэгтээ хүүхдээ оруулах нь хамгийн том асуудал болчихсон. Бид хүн амаа өсгөмөөр, боловсролтой болгомоор байдаг. Гэтэл цэцэрлэг, сургууль нь хүрэлцдэггүй, зарим тохиолдолд гэр орноос асар хол зайд байх жишээтэй. Өнөөдөр бидэнд чанартай боловсрол хэрэгтэй байна. Боловсролтой иргэд олон болж байж улс орон хөгжинө. Харин манайд чанартай боловсрол олгох газар цөөн байна шүү дээ. Иймэрхүү л дүр төрхтэй байна. Сургуулийн хүртээмжийг илүү болгоно гэдэг нь зөвхөн сургуулийн барилга биш, илүү хүндээ хандаж, багш нартаа хөрөнгө оруулалт хийж, чадавхижуулах, ажиллаж амьдралын нөхцлийг сайжруулах, илүү нөөц бололцоо өгөх замаар чанаржуулах хэрэгтэй. Иймэрхүү бодит байдал шийдлийг хүлээж байна гэж би харж байна.

**-Төлөвлөлтийг эвдсэнээс болоод машины зогсоолоос авахуулаад олон асуудал ургаж гарч ирээд байгаа байх?**

-Ердөө л тийм шүү дээ. Зүгээр энгийн юм ярья. Баянгол дүүргийн хамгийн том асуудал бол машины зогсоол. Хүүхдийн тоглоомын талбай. Өнөөдөр Баянгол дүүрэгт гайгүйхэн машины зогсоолтой аж ахуйн нэгж, орон сууцны хороолол байна уу. Байхгүй. Яагаад гэвэл өмнө нь байсан төлөвлөлтийг бүгдийг нь эвдсэн. Тоглоомын талбай дээр нь баахан байшин бариад л дуусгасан. Одоо хүүхдийн тоглоомын талбай доогуур нь машины зогсоол бариад, дээр нь хүүхдүүдээ тоглуулах л нэг арга байна. Гэтэл Европын орнууд бол энд зургаан давхар байшин л барина гээд хуульчлаад өгчихдөг. Тэгэхээр хот нь нягтрах биш тэлж явдаг. Машины зогсоол ч асуудалгүй болно. Хүүхдийн тоглоомын талбайд нь машин тавиад эхлэхээр бяцхан үрс чинь эрүүл байх аргагүй болно. Хүүхдүүдэд нь тоглох тоглоомын талбай байхгүй болохоор гэртээ орж компьютер тоглодог болно. Цаашлаад хараа муутай, жингийн илүүдэлтэй, дархлаа султай болж хувирна. Ийм л иргэдийг бид бэлдэж байна шүү дээ. Баянголчуудыг нь Баянголын хүн төлөөлж байж л нийгмийн асуудлыг нь ойлгоно шүү дээ. Би энд сайхан байхад нь амьдарч байсан. Намайг бага байхад төлөвлөлт үнэхээр мундаг байсан. Олон хоккейн талбайтай. Баянгол дүүрэгт хоккейн улсын аварга шалгаруулах тэмцээн болдог байлаа. Одоо байхгүй. Ганцхан ширхэг хөлбөмбөгийн талбай л байна. Бүх талбайд нь барилга барьчихсан. Хүүхэд гэлтгүй залуу үеийнхний цаг зав, чөлөөт цагаа зөв, зохистой өнгөрөөх газар алга. Архидан согтуурах баар ресторан л байна. Усан спортын бассейн, фитнесс клуб гээд спортлог, оюунлаг тал руу хөгжүүлэх боломжуудыг нь нээж өгөх ёстой. Дэмий тэнэх, зорилгогүй байна гэдэг энэ нийгмийг муухай харагдуулаад байгаа архидалт руу түлхээд байна. Ингэж болохгүй ээ. Тиймээс ирээдүй үеэ зөв хөгжих тал дээр илүү анхаарал хандуулахад төр хөрөнгө харамгүй зарцуулах шаардлагатай.

Ер нь өнгөрсөн 20-оод жилд нийгмээрээ бид хөгжиж байгааг би ойлгож байгаа ч маш олон нийгмийг хамарсан асуудлууд дээр олон жилийн туршлагатай хүмүүс чимээгүй нүдээ аниад өнгөрөөд байдагт харамсдаг. Магадгүй олон жил хүн нэгэн ижил бүтцэд, өөрийн байгуулсан системд байгаад байхаар 20 жилийн өмнөхтэй харьцуулаад амьдрал сайн байгаа юм шиг харагддаг болчихдог байх.

**-Асуудал бол хаана ч байгаа. Тэр дундаа 70 дугаар тойрогт их онцлогтой. Нэг хэсэг нь орон сууцанд амьдардаг. Нөгөө хэсэг нь гэр хороолold. Эдгээр хүмүүсийн тулгамдаж байгаа асуудал ерөнхийдөө ижил юм шиг мөртлөө нөгөө талаасаа арай өөр. Тийм болохоор асуудлыг яаж шийдвэл зүгээр юм бол?**

–Хэд хэдэн шийдлүүд байж болно. Нэн түрүүнд боловсролдоо л анхаарах хэрэгтэй. Үндсэн хуулинд хүүхэд ерөнхий боловсролыг үнэгүй эзэмших эрхтэй гээд заачихсан байдаг. Гэтэл өнөөдөр хувийн, өндөр төлбөртэй сургуулиуд нь илүү чанартай боловсрол олгож байна. Уг нь гэр хороололд амьдарч байгаа Должин эмээгийн ач, 61 дүгээр байрны иргэн Доржийн хүү, Зайсанд амьдардаг хэн нэгэн даргын хүүхдийн боловсрол эзэмших гарааны байдал тэгш байх ёстой. Хэнийх нь ч хүүхэд бай хамаагүй суралцах чадвартай, шалгалтаа өгөөд тэнцэж л байвал сургуулийнх нь төлбөрийг улсаас төлж байх хэрэгтэй. Яагаад гэвэл Үндсэн хуулиараа ерөнхий боловсролыг үнэгүй эзэмших эрхтэй гээд заачихсан байгаа биз дээ. Гэтэл одоо цагт мөнгөтэй, мөнгөгүйгээр нь ангилчихаад байна. Бид гэрэлт ирээдүйг авчирна гэж л бодож байгаа бол боловсролтой иргэн хамгийн хэрэгтэй. Боловсролтой иргэнийг яаж бий болгох вэ гэвэл суурийг нь л сайн тавих хэрэгтэй. Харин суралцах чадвартай, шалгалтыг нь давж чадаж байгаа хүүхдүүдийн төлбөрийг улсаас төлчих л ёстой. Тэгвэл хувийн сургуулиуд илүү ихээр байгуулагдана. Цаашлаад, улсын сургуулиуд нь хүүхдээ татахын тулд улам чанаржина. Гэр хороололд амьдарч байгаа Должин эмээгийн ач чанартай сургуулийн шалгалтад нь тэнцээд, суралцчихвал ирээдүй нь тодорхой болно шүү дээ. Иймэрхүү байдлаар цэцэрлэг, сургуулийн, боловсролын асуудлыг шийдмээр байна. Энэ бол хийсвэр зүйл огт биш. Канадад яг ийм маягаар асуудлаа шийдсэн байдаг. Боловсролд хөрөнгө оруулна гэдэг бол багш, эцэг эх, хүүхдэд бүгдэд нь жигд оруулж байж бид урт дуаан жил үргэлжлэх суурь тавигдана. Зүгээр сургуулийг тендерээр барих бол дөнгөж л эхлэл төдий зүйл шүү дээ.

Түүнээс гадна эрүүл мэндийн асуудлыг бас шийдмээр байгаа юм. Хувийн том эмнэлгийн үзүүлдэг үйлчилгээ огт өөр. Тэгэхэд Баянголын нэгдсэн эмнэлгийн үзүүлдэг үйлчилгээ, чанар, тоног төхөөрөмжийн хүчин чадал хамаагүй муу байх жишээтэй. Одоохондоо хүмүүст нэг их ялгаатай санагдахгүй байж болно. Гэтэл хувийн том эмнэлэгт ажиллаж байгаа эмч 2-3 сая, улсын эмнэлгийнх нь 500 мянган төгрөгийн цалин аваад явбал яваандаа чанарын асар том ялгаа бий болно. Тийм болохоор эмнэлгийн асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй. Өнөөдөр бид насаараа эрүүл мэндийн даатгал төлж байгаа. Гэтэл хүнд өвчин тусах үед улсаас нөхөн олговор олгохгүй байгаа шүү дээ. Элэгний вирустэй хүмүүсийн сарын эмчилгээнийх нь зардал сарын 1.5 сая төгрөг, сахарын өвчтэй хүмүүсийнх түүнээс ч өндөр. Гэтэл төрөөс үзүүлж байгаа эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж маш муу. Хувийн эмнэлэгт үзүүлэх гэхээр төлбөрийг нь дийлдэггүй. Канадад энэ асуудлыг бас л амархан шийдсэн байх жишээтэй. Хүн дуртай эмнэлэгтээ үзүүлдэг. Төлбөрийг нь улсаас төлдөг.Тийм нийгэм бидэнд хэрэгтэй.

**-Энэ бүхэнд хөрөнгө хэрэгтэй биш үү?**

Мэдээж энэ бүхэнд хөрөнгө, мөнгө шаардлагатайг ойлгож байна. Манай улсын хувьд боломжгүй зүйл биш, бидний амьдралд аль чухал вэ гэдэг дээр төр нь оновчтой шийдвэр гаргах хэрэгтэй ш дээ.

Гэтэл өнөөдөр улстөрчдөд зориулсан хүчтэй гэгддэг төртэй болж. Хүмүүсийг барьж авдаг, хорьдог, цагддаг, эсвэл хэн нэгний бизнесийг булааж зогсоож нөгөөд шилжүүлдэг. Зөвхөн удирдагчийн хүссэнээр бүх зүйл хөдөлж байдаг болчихсон. Ийм нийгмийг бид хүсээгүй, ийм төрийг ард түмэн хүчтэй төр гэж хэлдэггүй. Бид хуулийн өмнө тэгш хүнийг хамгаалах хүчтэй, боловсролтой, чинээлэг иргэнтэй нийгмийг л бүтээх ёстой. Ард түмний хүчтэй төр гэдэг нь амьдралаа авч явааг нь дэмждэг, үгүйд нь тусалдаг зохицуулдаг чадамжтай төрийг л гэж ойлгоно. . Өнөөдөр манай иргэдийн амьдралын төвшин үнэхээр өөр, эрс тэс ялгаатай байна. Тийм болохоор нийгмийн асуудлыг төрөөс зөв бодлогоор шийддэг байх ёстой гэж яриад байгаа юм. Зөвхөн манай Баянгол дүүрэгт ч биш улсын хэмжээнд энэ бодлогыг хэрэгжүүлэх цаг нь болчихсон гэж бодож байна. Энэ бол иргэн рүүгээ чиглэсэн хамгийн том шийдэл гэж хараад байгаа юм.

Өнөөдөр бидний хамгийн том асуудал утаа гээд л байдаг. Яг үнэндээ бидний хамгийн том асуудал бол хүртээмжтэй боловсрол, чанартай эрүүл мэндийн үйлчилгээ, амьдралд хүрэх цалинтай ажил гурав л байна шүү дээ. Утаа руу 200, 300 тэрбумаар нь шидээд байж болж байна. Яагаад хүүхдүүдийнхээ чанартай, өндөр боловсрол, эрүүл мэндэд мөнгө зориулж болохгүй гэж.

Гэтэл АСЕМ-д байхгүй гээд байсан хөрөнгө чинь гараад ирж л байгаа биз дээ. Ингэж болохгүй. Ердөө энэ бүхний буруутан нь төр засаг, удирдаж буй хэсэг нөхдүүд. Хүүхдийн тоглох тоглоомын талбайг нь булаачихаад эндээс сонгогдоно гээд явж байж таарахгүй.

Бас тэгээд улсад мөнгө байхгүй гэчихээд, сонгууль болонгуут найман жилийн өмнө амласан, дөрвөн жилийн өмнө хоосон хувьцаа гэж молигодоод, одоо гуравны нэгийг нь хүүхэд чихрээр хуурч байгаа юм шиг зүгээр л ЗГ-ын шийдвэр гаргаад мөнгө хэвлээд л тараана гэнэ. Бодит эдийн засгийн өгөөж биш шууд хоосноос мөнгө хэвлэх аргаар ингэж өгөхөөр ард түмэнд 300 мянган төгрөг өгч байгаа юм шиг боловч тун удахгүй юмны үнэ, инфляци өсөөд, амьжиргааных нь хэдээс хумслагдаад дүндээ л дүн болно доо. Бидний мөнгийг бидэнд өгөөд хариу нэхээд байгаа юм уу.

Нөгөө том төслүүд нь эдийн засгийн эргэлтэд ороод өгөөжөө өгсөн юм байхгүй. Зүй нь манай төр засагт байсан нөхдүүд оновчтой шийдвэр гаргасан бол бидний сая төгрөгний хувьцааны үнэ өсөж, жилийн өгөөж нь та бидэнд 10-15 хувийн ашиг өгөх ёстой. Өнгөрсөн 5-6 жилд бид нийтдээ нэг саяас 500-600 мянган төгрөгийн өгөөж дор хаяж авах

ЧУХАЛ ХҮН

# “ХАВДАР” БАЙГААГИЙН НЭГ НЬ МАНАН

гуравдагч сонголт байдаг гэдгийг нотлох хэрэгтэй.Том нам гэж байгаа боловч түүний цаана 20, 30хан хоёр талаас нь цавчсаар байгаад унагаадаг буруу жишиг ард түмний нүдэнд ил болж.–

ёстой байхад буруу шийдвэрийн алдаагаа нууж 300 мянгыг тарааж байна уу. Иргэд 300 мянгаар зарах биш 600 мянгынхаа алдагдсан боломжийн хариуцлагыг нэхэх хэрэгтэй.

Ингээд л үр бүтээлгүй баахан зардал болоод л жинхэнэ хэрэгтэй зүйлдээ анхаарал хандуулахгүй байна.

## Гэр хорооллын дахин төлөвлөлтийн урагшлах замыг төр өөрөө хааж байна

**-Гэр хороололд амьдарч байгаа иргэдийн орчин нөхцөл хэцүү талдаа л байгаа. Ядаж байхад сүүлийн хэдэн жил эдийн засгийн хямралаас болоод ажилгүй иргэдийн тоо нэлээд өслөө шүү дээ?**

-Мөрийн хөтөлбөрийн тэргүүн шугаманд ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллахаар тусгасан байгаа. Гэр хорооллын оршин суугчдын амьдралын боломж тааруухан байна. Ихэнх нь ажилгүй болчихож. Ажилгүй болсон шалтгаан нь угаасаа ойлгомжтой. Эдийн засаг хямарсан. Улс төрөөс хамааралтай эдийн засаг хямарсан гэж хэлбэл илүү оновчтой байх. Эдийн засаг хямрахаар бизнесийнхэн зардлаа хумиж эхэлдэг. Зардлаа хумиж эхлэхээр хамгийн түрүүнд жирийн ажилтнуудад цохилт ирдэг. Тийм болохоор иргэдийг ажлын байртай болгох хэрэгтэй юм. Улс төрчдийн хийгээд байдаг нэг зүйлийг би ойлгодоггүй. Тухайлбал, Тавантолгойн асуудал байна. Төмөр зам барих ажил байна. Бас л олон мянган хүн ажилтай болох төсөл. Өргөн, нарийн цариг гэдэг яг үнэндээ хоёрдугаар асуудал. Гагцхүү маш олон ажлын байр бий болгох төсөл гэж хэлж болно. Ийм л бодлогогүй үйлдлүүдээ улстөрчид зогсоох хэрэгтэй. Иргэдээсээ ажлын байрыг нь булаадаг үйлдлээ болих шаардлагатай байгаа юм. Өнгөрсөн хэдэн жилд уул уурхайг тэр чигээр нь зогсоолоо. Эрх баригчид баахан лицензийг цуцлаад, компаниудын ажлыг зогсоодог. Хүмүүсийн бизнесийн үйл ажиллагааг зогсоодог бүлэглэл өнөөдөр маш их болчихлоо. Гэрээ нь ямар ч байж болно, Монголд ашигтай байдлаар засах шаардлага бол мэдээж бий. Гэхдээ гэрээ хийчихсэн бол дараагийн гэрээ орж иртэл ажлыг нь зогсоож болохгүй. Тэр ажил явдгаараа явах л ёстой. Тэнд ажиллаж байгаа хүмүүсийн цалин мөнгөний асуудал чухал. Ажил зогслоо гэхэд хамгийн их хямрах хүмүүс нь мэдээж жирийн ажилчин иргэд. Улстөрчдийн оролцож болох, болохгүй зүйлсийг зааглаж өгмөөр байгаа юм. Мөн янз бүрийн бүлэглэлүүдээс хамгаалдаг төрийн институт гэж байх ёстой. Төрийн үүрэг бол хувийн хэвшлийнхний ажиллах боломжийг нь олгох. Хэрвээ хуулийн дагуу шүүгч тэр ажлыг зогсоогоогүй л бол хэн ч зогсоох эрх байхгүй. Энэ бүхнээ больчих юм бол бид ажлын байрны асуудал яриад сууж байхгүй шүү дээ. Аяндаа ажлын байр нэмэгдээд, ард түмний амьдрал бага багаар сайжраад л явчихна. Дэмий хоосон мөнгөний амлалт, уурхайд эзэмших хувь хэмжээ, царигний өргөн нарийнд санаа зовж байхаар эдийн засгаа хөл дээр нь босгож мянган мянган ажлын байр бий болгох, түүндээ урьдчилан иргэдээ хэрхэн бэлтгэх, дахин сургаж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, чанартай ажлын байраар хангаж, иргэдийн амьдрал ахуйг сайжруулахыг бодох хэрэгтэй.

Зөвхөн төрийн дээр төсөв царцуулж буй нөхдөд л тэр хоосон зүйл хэрэгтэй болохоос бидэнд амьдралаа гэр бүлээ аваад явах боломж илүү чухал.

**-Гэр хороололд амьдарч байгаа иргэдийн ихэнх нь тохилог орон сууцанд амьдрах хүсэлтэй байгаа. Төр засгаас дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлээд, ажиллаж л байна. Гэхдээ хангалттай хэмжээнд хүрээгүй. Тэгвэл 70 дугаар тойргийн хувьд Зурагтын гэр хороолол байна. Утаа ихтэй. Энэ хүмүүс рүү хандсан, дахин төлөвлөлтийн зөв бодлого хэрэгтэй байгаа юм. Энэ тал дээр таны бодож, төлөвлөж байгаа ажил юу байна?**

-Манай компани Сонгинохайрхан дүүрэгт дахин төлөвлөлт хийж байгаа. Хотын хэмжээнд 3-4 компанийн төсөл нэлээд амжилттай явж байх шиг байна. Мэдээж энэ зөв ажил. Гэхдээ шүүмжлэлтэй хандах зүйл бас байгаа юм. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн эрхийг ийм олон компанид өгч болохгүй байсан. Эхний шалгуурт нь найман компани гарч ирсэн. Тэр компаниудын үр дүнг үзэх ёстой байсан юм. Илүү цар хүрээтэйгээр ажиллах боломжийг нь олгох хэрэгтэй байсан юм. Нэгэн зэрэг 40 гаруй компанид зөвшөөрөл олгочихоор өнөөх төсөл нь үнэ цэнэгүй болчихож байгаа юм. Дунджаар 20 хувийн хүүтэй банкнаас зээл авч ажлаа хийдэг. Зарж байгаа бүх бүтээгдэхүүнд банкны 20 хувийн хүү шингэсэн байдаг. Барьсан орон сууц нь хугацаандаа зарагдахгүй бол банкинд алданги төлнө. Төрийн хийж байгаа ажилд тийм дарамт байхгүй шүү дээ. Хувийн компаниудыг нийгмийн хариуцлагаа ухамсарлаад, төсөл хэрэгжүүл, үнээ хямдруул гээд байдаг. Төрийнхөн нь болохоор хоосон газар дээр, хүүгүй мөнгөөр барилга бариад байгаа юм. Энэ чинь гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил амжилттай урагшлах боломжийг төр өөрөө хаагаад байгаа гэсэн үг. Манай тойрогт, Зурагт орчимд гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлыг явуулбал боломж бий. Өндөрлөг газар болохоор хот их гоё харагдахаар. Харин төрөөс дараа дараачийн төслөө туршлагатай компанид өгөх хэрэгтэй. Хэрвээ Зурагт орчмыг дахин төлөвлөлтөд оруулах асуудал наштай шийдэгдвэл өмнөх төлөвлөлтөд гаргасан алдааг гаргуулахгүй ажиллахад яах ёстой вэ, яавал ард иргэдэд ашигтай, хурдан байдлаар шийдэж, хэрэгжүүлэх вэ гэсэн тактик миний тархинд байгаа. Гэр хорооллын дахин төлөвлөлт хийхэд иргэдийн дэмжлэг маш их хэрэгтэй байгаа юм. Бид энэ хэсэгт дахин төлөвлөлт хиймээр байна гээд гарын үсгээ зуруулаад, нийслэлийг шахах хэрэгтэй. УИХ-д МАНАН-гаас өөр хүн орохгүй л бол энэ мэт шийдвэрийн алдаанууд зогсохгүй.

**-70 дугаар тойрогт Гандан орчим багтаж байгаа. Тэгвэл сүүлийн 20-иод жил Гандang төвийн шугамд холбоно гэж ярилаа. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл хийгээгүй л байна. Зарим нь Гандан энэ хэвээрээ үлдэх ёстой ч гэж ярих нь бий. Таны бодлоор Гандангийн дэнжийг яаж өөрчлөх ёстой вэ?**

-Манайхаас өөр орон байсан бол энэ газрыг соёлын өвийн зориулалтаар тусгай хэрэгцээнд авах байсан. Би л хувьдаа тэгж бодож байна. Тусгай хэрэгцээнд аваад, цэцэрлэгт хүрээлэн барих байсан. Иргэд амралтын өдрөөрөө очдог, үр хүүхдээ зугаалуулдаг, Гандан хийддээ мөргөдөг тийм л цэцэрлэгт хүрээлэн болгоно. Оршин сууж байгаа хүмүүсийг нь мэдээж хөөчихгүй шүү дээ. Солонгос шиг хуучны соёлын өв бүхий барилга, гэрт байхыг дэмжиж, соёлын өвийг хамгаалах сангаас харин ч сэргээн засварлаж, дэд бүтцийг нь шийдэж өгөх хэрэгтэй. Тэр нь ч бараг илүү хямд тусна. Монголын түүхийн онцлогийг хадгалсан, нийслэлийнхэн, цаашлаад гадна, дотны аялагчид ирдэг үндэсний түүхэн хороолол, зугаалдаг цэцэрлэг, мөргөдөг сүм хийд хэрэгтэй байгаа юм. Янз бүрийн үнэр танар болсон гудамжаар алхаад, Гандaнд очиж мөргөх таатай санагддаггүй л байх. Сүм дуган гэдэг цэвэр ариун газар байх ёстой. Өөр аль ч оронд ийм бохир орчин бүхий сүм хийд байхгүй. Уг нь Гандан Улаанбаатар хотын хамгийн ариун газар шүү дээ. Харамсалтай нь битүү гэр хороолол, шээс шивтэр үнэртсэн газар болж. Харин цэцэрлэгт хүрээлэн болгочихвол аялал жуулчлал хөгжүүлэхэд ч илүү боломжтой болно. Манай улсаас өөр орон ийм л шийдэлд хүрэх байсан. Манайхан болохоор дэд бүтэц татаж, төвийн шугамд холбох л юм яриад байдаг, байшин барилга нь хүртэл соёл, түүхээ хадгалсан байх ёстой, тэрэнд нь улс дэмжих хэрэгтэй. Хэрвээ тэнд өндөр байшингууд бариад унах юм бол өнөөх Гандан нь ч харагдахаа болиод, тэр хавьд нь баахан машин аваачиж тавиад, хөл толгойгүй л болно. Тийм зүйл энд хэрэггүй ээ.

...Би л хувьдаа тэгж бодож байна. Тусгай хэрэгцээнд аваад, цэцэрлэгт хүрээлэн барих байсан. Иргэд амралтын өдрөөрөө очдог, үр хүүхдээ зугаалуулдаг, Гандан хийддээ мөргөдөг тийм л цэцэрлэгт хүрээлэн болгоно. Оршин сууж байгаа хүмүүсийг нь мэдээж хөөчихгүй шүү дээ. Солонгос шиг хуучны соёлын өв бүхий барилга, гэрт байхыг дэмжиж, соёлын өвийг хамгаалах сангаас харин ч сэргээн засварлаж, дэд бүтцийг нь шийдэж өгөх хэрэгтэй. Тэр нь ч бараг илүү хямд тусна...

## Манайд хоёр “хавдар” байгаагийн нэг нь банкны систем

**-Хороолол орчим бол Улаанбаатар хотын худалдааны гудамж гэж хэлж болохоор газар шүү дээ. Тиймдээ ч олон бизнес эрхлэгч, худалдаачидтай. Тэдэнд хандсан бодлого ч бас дутагдаад байгаа юм?**

-Дэлгүүр ажиллуулдаг хүн, жижигдундбизнесмэн,наймаачид ихтэй. Тэд бүгдээрээ зээлийн хүүгийн дарамтад орчихсон байна. Өнөөдөр Монголд зээлийн хүүгийн дарамтад ороогүй хүн гэж байхгүй. Манай банкны жилийн зээлийн хүү 24 орчим хувьтай байгаа. Түүнээс ч өндөр нь бий. Банк бус санхүүгийн байгууллагаас зээл авбал жилийн 48 хувийн хүүтэй. Бүр жижиг бизнес эрхлэгчид ломбарднаас мөнгө зээлж байгаа. Жилийн 80-100 хувийн хүү төлдөг. Ийм байхад Монголд яаж бизнес хөгжих юм бэ. Манайд хадгаламжийн хүү хэтэрхий өндөр байдаг. Хадгаламжийн хүү зээлийн 16 хувийн хүүтэй байгаа. Гэтэл нийт хадгаламжийн 95 хувийг нь 1000 гаруйхан өрх эзэмшдэг. Манай банкуудын жилийн 16 хувийн хадгаламжийн хүү бол ердөө л тэр өрхүүдэд зориулсан л хүү шүү дээ. Манайх хадгаламжийн хүүгийн орлогоос татвар авдаггүй орон. Татвар авахгүй байж болно оо. Гэхдээ хадгаламжийн хүү бага байх ёстой. Гэтэл өнөөдөр мөнгөтэй хүмүүс ямар ч ажил хийхгүйгээр амьдрах боломжийг олгож байна, манай улс. Тэрбум төгрөгтэй байлаа гэхэд зүгээр сууж байгаад жилийн дотор 160 сая төгрөгтэй болчихно. Ямар ч бизнес эрхлэх, ажил хийх шаардлагагүй. Гэтэл бусад компаниуд, аж ахуйн нэгж, ард иргэд тэдний хадгаламжийнх нь хүүг төлж өгөхийн төлөө хөдөлмөрлөж байна гээд бодоод үз. Тийм болохоор хадгаламжийн хүүг таваас доош байлгахаар хуульчилж байж байдал сайжирна. Банк таваас доош хувийн хүүтэйгээр хадгаламжаа авдаг болчихвол зээлээ 10-аас бага хувийн хүүтэй өгнө. Үүнд нэг их ухаан зарцуулаад байх зүйл биш шүү дээ. Хадгаламжийн хүүгээ бууруулчих. Тэгвэл зээл, ипотекийн,ломбардныхүүбуурна. Дагаад бараа бүтээгдэхүүн, байрны үнэ ч буурна шүү дээ. 26 жил банкны зээлийн хүү огт өөрчлөгдөөгүй. Ихэнх аж ахуйн нэгжүүд олж байгаа хамаг мөнгөө банкны хүүнд өгөөд л таарч байгаа шүү дээ. Хувийн бизнес эрхлэгчид бүгд мэдэх байх. Жилийн 20-иос дээш хувийн өгөөжтэй бизнес гэж бараг байхгүй. Өнөөдөр Улаанбаатар дэлхийн хамгийн өртөг өндөртэй хотуудын нэг болчихсон. Шалтгаан нь нөгөө л банкны зээлийн хүү. Яагаад гэвэл аж ахуй нэгжүүд 20 хувийнхаа зээлийн хүүг төлөөд, цаана нь жаахан ч гэсэн ашигтай ажиллахын тулд бүтээгдэхүүнийхээ үнийг нэмдэг. Маш олон компани байгууллагадаж байгаа болов ч 95 хувь нь хоёр жил хүрэхгүйн хугацаанд дампуураад дуусдаг. Банкны хүүгийн дарамтаас болж тэр шүү дээ. Тэгэхээр бизнес эрхлэгчид, наймаачид, худалдаачдын асуудлыг шийдье гэвэл банкны хүүг хуульчилж өгөх л хэрэгтэй. Монгол банкны Ерөнхийлөгч бол аль нэг банкны төлөөлөл л байдаг. Түүнээс болоод л ашиг сонирхлын зөрчил үүсч, өөрсөддөө ашигтай зүйл хийж эхэлдэг юм. Ерөөсөө Монголын төрд хоёр том хавдар байна. Нэг нь МАНАН, нөгөөх нь банкны систем. Банкны системтэй тэмцэнэ гэхээр банкуудыг хаагаад, байшин барилгыг нь эвдэж сүйтгэ гээд байгаа юм биш. Зүгээр л хадгаламжийнхаа хүүг буулгах л юм шүү дээ. Хуулиараа 20 тэрбум төгрөгтэй хүн банк байгуулах лицензийг хоёр сарын дотор л авах боломжтой. Гэтэл манайд гадныхан орж ирээд банк байгуулах гэхээр 2-3 жилээр хүлээдэг. Зөвшөөрөл өгдөггүй. Ингээд л банкны системд өрсөлдөөн байхгүй болчихсон. Тэгээд гаднаас банк орж ирлээ гэж бодоход манай хуулиар л үйл ажиллагаа явуулна. Уг нь Монгол Улсын иргэд хожиж байвал төр ажлаа хийх л ёстой. Монгол хүний эрх ашиг номерт явж байна гэдэг нь чухал болохоос биш банкны систем хэдэд явах нь чухал биш шүү дээ. Ингэчихвэл банкны систем доголдоно гээд л худлаа яриад байдаг. Би хувьдаа тийм зүйл болохгүй л гэж боддог.



*Баянгол дүүргийн 23-р хороонд*

**-Энэ хоёр хавдрыг “мэс засал” хийгээд авч хаях боломж ойрын хэдэн жилд байна уу?**

-Боломжтой. Гэхдээ иим “мэс засал”-ыг хийхийн тулд шинэ хүмүүс л хэрэгтэй байна. Гар утасны зайгаар жишээ авъя л даа. Цэнэглэдэг байсан ч гэсэн өдөр өнгөрөх тусам мууддаг. 100 хувийн цэнэг авахаа болино. 70, 40, 30 хувь болоод л зайных нь чадал буураад байдаг. Сүүлдээ байнгын цэнэглэгчинд залгаж байж ажиллах жишээтэй. Уг нь бол хуучин зайгаа хаяад, шинийг авах нь зөв шийдэл шүү дээ. Үүнтэй адил бидэнд ч бас шинэчлэл хэрэгтэй. Өнгөрсөн 26 жилийнхугацаандодоогийнэдийн засаг, санхүүгийн системийг бий болгосон хүмүүс, улс төрийн намууд иргэдэд, аж ахуйн нэгж бизнесүүд, банкуудад, Монгол хүнд ашиггүй нэрмээс болж буй тогтолцоог сольж шинэчилж чадахгүй юм байна. Өөрсдийн давуу талтай байдлаа өөрчлөхийг хүсэхгүй юм байна.

МАНАН-гаас өөр сонголт байхгүй юм шиг явж ирлээ. 70 дугаар тойргийн хувьд АН-ын, МАН-ын УИХ-ын даргын албан тушаалтнууд өрсөлдөөд унадаг уламжлал болсон халгаатай тойрог. Энэ удаад ард түмэндээ гуравдагч сонголт байдаг гэдгийг нотлохыг хүссэн. Манай улсын хөгжил, эдийн засгийн чадавхи энэ хоёр намын сонголтод үндэслэсэн гэж хэлж болно. Нэг нь ардын хувьсгал, нөгөө ардчилсан хувьсгал ярьдаг болохоос биш ирээдүйгээ харсан бодлогын нам байхгүй болчихсон. 2020 он, 2030 онд яаж хөгжих ёстой юм гэхээсээ илүүтэй зөвхөн гишүүнчлэлээр засаглал тогтоох гэж оролддог. Нам гэж байгаа боловч түүний цаана 20, 30-хан оффшортонгууд нуугдаад, хатуу гишүүнчлэлээр ээлжлэн 26 жил захирч байна. Шинэ хүн, шинэ хүчин гарч ирэх гэхээр хоёр талаас нь цавчсаар байгаад унагаадаг буруу жишиг ард түмний нүдэнд ил байгаа шүү дээ.

**-Бүх хууль дүрмээ зөвхөн өөрсөддөө зориулж баталж байгаа өнөө үед “мэс засал” хийх шинэ үеийн залуучууд гарч ирэх боломж тун бага юм шиг санагдаад байна?**

-Хуулиар дарангуйлах гэдэг хэлбэр рүүгээ орчихсон байна. Өөрсөддөө зориулж хууль гаргадаг. 2012 оны сонгуулийн хууль байна. Холимог системтэй болгоод, настайчуудаа намын жагсаалтаар гаргачихсан. Гэтэл тэр хууль нь Үндсэн хууль зөрчсөн гэдэг шийдвэрийг Үндсэн хуулийн цэц гаргасан. Уг нь манайд хууль биеллээ олдог байсан бол жагсаалтаар гарч ирсэн 28 хүн тэр даруй УИХ-ын гишүүн биш болох ёстой байлаа. Гэтэл манайд болохоор өнөөдүүл нь дараагийнхаа сонгуулийн хуулийг өөрсөддөө зориулаад баталж байгаа юм. Энэ чинь хуулиа зөрчсөн хэрэг. Уг нь төрийн эргэлт гэсэн үг. Ингэж л хуулиар дарамталж байна. Нөгөө талаар хуулиа зөрчиж хулгай хийдэг болчихсон. Бид Чингис бондоор 2012 онд 1.5 тэрбум ам.доллар авчирсан. Дараа нь Японоос 500 сая ам.доллар авсан. Энэ мэтээр сүүлийн дөрвөн жилд таван тэрбум ам.долларыг зүгээр л цацчихсан улс шүү дээ. Уг нь анхны авсан хоёр тэрбум ам.долларыг хэн нэгэн хүнд зарцуулах эрх өгөөгүй. УИХ мөнгө зарцуулах эрхийг төсөвт суулгаж өгдөг юм. Төсвийн тухай хуулиа батлаад, энэ мөнгийг ийм зүйлд, тэрийг нь түүнд зарцуулаарай гэж хуульчилж өгдөг. Гэтэл хоёр тэрбум ам.долларыг хуульгүйгээр шууд үрэн таран хийсэн. Энэ бол асар том хулгай. Замын тендер авахад 10 хувийн бонус өгдөг гэдгийг хүн бүр л ил тод мэдэж байгаа шүү дээ. Тэгвэл хоёр тэрбум ам.доллараас 10 хувийг нь өгсөн гээд бодоод үз дээ. Өнгөрсөн дөрвөн жилд маш их зам барилаа. Хоёр тэрбум ам.доллараар зам барьсан. Яагаад зам барьсан бэ гэхээр 10 хувийг нь авах гэж л тэр. Хуульчилсан дарангуйлал, дээрэм гэдэг чинь л энэ. Манайх энэ зам руу орчихлоо. Энэ хавдарт “мэс засал” хийх шинэ залуу үеийн төлөөлөл яах аргагүй хэрэгтэй цаг нь ирсэн. Үүнийг сонгогчид л шийдэх шинэ цаг үе хаяанд ирчихээд байна гэдгийг энэ дашрамд онцлох нь зүйтэй болов уу. Бид 2016 оны сонгуулиар эдийн засаг, нийгмийн хөгжлөөс хойш татаж буй хоцрогдсон улс төрийн хамууд биш, гэр бүлийнхээ ирээдүй, эцэг эхийнхээ эрүүл мэнд, хань ижлийнхээ ажил хөдөлмөрийн төлөө өөрсдийгөө сонгох цаг иржээ. Энэ өөрчлөлтийг сонгогч та, би, бид бүгдээрээ хамтарч хийнэ, нийгэмд шинэлэг уур амьсгал бий болгоно гэдэгт итгэж байна. Итгэл найдвар бол бидний хамтын зүтгэл, хариуцлагын эхлэл байх болов уу. Бид зөвхөн хамтдаа л өөрчлөлтийг хийж чадна.

*УИХ-ын сонгуулийн 70 дугаар тойрогт бие даан нэр дэвшигч Хассуурийн Ганхуягийн сонгуулийн штаб*

ОНЦЛОХ ХУУДАС

Õ Ý Í íü Õ Ý Í áý?

# БОЛОВСОРСОН, ТӨЛӨВШСӨН ЗӨВ ХҮН

Н.ПУНЦАГБОЛД

*"Монголын мэдээ" сонин 2016 оны парламентын ээлжит сонгуульд өрсөлдөж буй хүмүүсийг "Хэн нь хэн бэ" буландаа онцолж сонгох, сонгогдохгүй шалтгааныг нь тоймлож байгаа билээ. Тэгвэл энэ удаагийн дугаартаа УИХ-ын сонгуулийн 70 дугаар тойрогт бие даан өрсөлдөж байгаа Хассуурийн Ганхуягийг онцолж байна.*

## СОНГОХ ШАЛТГААН

### Баянголын унаган хүү

УИХ-ын 70 дугаар тойрогт бие даан нэр дэвшигч Хассуурийн Ганхуяг нь Баянгол дүүргийн унаган иргэн. Орой дээрээ "Аз жаргал" гэсэн бичигтэй 61 дүгээр байранд амьдарч байсан үүх түүхтэй.Түүний хүүхэд ахуй цаг тэр чигээрээ Баянгол дүүрэг, дөрөвдүгээр хороолол, өндөр цэнхэрүүдийн дунд өнгөрсөн. Үүгээрээ тэр бусад нэр дэвшигчдээс ялгаатай. Хоёр том намаас нэр дэвшиж буй өрсөлдөгчид нь Өвөрхангай аймгийн хүмүүс. Насаараа тэр тойрогт өрсөлдөж явсан хүмүүс гэнэтхэн Баянгол дүүргээс нэр дэвшиж байгаа. Тэр хүмүүсийг Баянголын, тэр дундаа 70 дугаар тойрогт сэтгэлгүй хандана гэсэнгүй. Харин Баянголын унаган иргэн илүү их сэтгэл гаргаж, иргэдээ илүү сайн ойлгоно гэж хэлэх гээд байгаа юм. Тэгээд ч тэр бидний л нэг, жирийн иргэн. Олон жил улс төрийн бохир тогоонд чанагдаагүй, бодож сэтгэж байгаа нь агаарт хөөрчихөөгүй. Жирийн иргэдийн амьдрал ахуй, тулгамдаж байгаа асуудлыг харах өнцөг нь дээдсүүдийг бодвол арай л өөр шүү дээ.

### Дэлхийд өрсөлдөх боловсролтой боловсон хүчин

Өнөөдөр парламентын суудалд санаархагчдын хэдэн хувь нь хүлээн зөвшөөрөгдөхүйц боловсролтой байгааг судалбал сонирхолтой тоо гарах байх. Бөхчүүд, дуучид, жагсагчаас авахуулаад боловсрол мэдлэгээр дулимагхан нөхдүүд олон байгаа шүү дээ. Тэр ч битгий хэл ганц ч сургууль төгсөөгүй хүмүүс төрд гарчихсан л явж байна. Төрийн жолоог олон сургууль төгссөн хүн атгадаггүй юм. Төрийн хар хүн гэдэг арай өөр ойлголт гэх мэтээр мушгих нөхдүүд олон бий.Тэгвэл Баянгол дүүргийн 70 дугаар тойрогт бие даан өрсөлдөж байгаа Тэрбээр Монголдоо МУИС-ийг төгсөөд зогсохгүй Солонгост сурсан мэдсэнээ улам баталгаажуулж, боловсролоо дээшлүүлсэн. Х.Ганхуягийн хувьд дэлхийд өрсөлдөхүйц өндөр боловсролтой боловсон хүчин бэлтгэдэг Харвардын их сургуулийг бизнес удирдлагын чиглэлээр төгссөн, Орос, Англи, Солонгос хэлийг төгс эзэмшсэн гэх мэтчилэн өнөөгийн төрд нэн хэрэгцээтэй төгс "бүтээгдэхүүн" гэж хэлж болно. Харвард төгссөн байхад Монголд төдийгүй дэлхийд үнэлэгдэхээр боловсон хүчинд тооцогдоно шүү дээ. Ийм боловсролтой, чадвартай залуучууд дэлхийн хэмжээнд сэтгэж, бусдын дайтай Монголын хөгжлийг өөрсдийн оюун тархиндаа цогцлоосноо хөрсөн дээр буулгахыг зорьж байна. Манай төрд яг ийм л залуус ус, агаар шиг нэн хэрэгцээтэй байна.

### Төлөвшсөн зөв иргэн

Гэрээ засаад төрөө зас гэдэг ардын мэргэн үг бий. Айл ч авч явж үзээгүй залуучууд улс удирдана гэж юу байх вэ дээ хэмээн манайхан бухимдах болсон. Яг үнэндээ бууръ суугаагүй, төлөвшөөгүй залуучууд улс төр рүү хэт улайрах болж.  Гэтэл Монголын улс төрд зөв бодолтой, чадвартай, төлөвшсөн, хөгжсөн хүн хэрэгтэй байна. Ядаж л амьдралаа зөв залаад аваад явж байгаа, хувь хүний хувьд хөгжчихсөн хүн улс орны хөгжил ярина биз дээ. Тэгвэл Х.Ганхуяг аль хэдийнэ төлөвшсөн, зорилготой, чадвартай нэгэн.  Манай монголчууд 40 хүрсэн эр, дөрөө дарсан ат гэдэг. Зүгээр ч нэг хэлчихсэн юм биш. Өөрөөр хэлбэл, алдаж оնож, сурч мэдэж, төлөвшиж чаддаг, хий нь гардаг гэдгийг л хэлээд байгаа юм. Олон залуучууд дөнгөж 25-30 насандаа улстөрд орохоор дайрч байхад тэр арай өөр замыг туулсан. 30 орчим насандаа бизнесээ эхэлж, олон хүнийг удирдаж, өнөөдрийг хүртэл ажиллаж яваа.  Энэ хугацаандаа хүн яаж төлөвших ёстой, тэр замаар л яваа хүн. Ийм л төлөвшсөн, зөв бодолтой, чадвартай, аль хэдийнэ бууръ суурьтай болсон хүнийг бид төлөөллөөрөө сонгох хэрэгтэй байна.

### Ажил олгогч, баялаг бүтээгч

Монгол Улсыг хөгжүүлнэ гэж олон ч хүн ярьж байна. Харамсалтай нь ам, ажил хоёр алд дэлэм зөрж байгаа нь худлаа биш. Яахав, Улаанбаатар хот өнгөө засч, өндөр байшингийн тоо нэмэгдэж байгаа нь үнэн. Гэвч улсын хөгжлийн гол үзүүлэлт болсон дундаж амьдралтай, ажилтай, орлоготой иргэдийн тоо буурсаар л.  Харин Х.Ганхуяг нэр дэвшигч ажилтай, орлоготой монгол хүний тоог нэмэгдүүлэхийн төлөө өөрийн эзэмшсэн мэргэжил, сурч боловсорсон бүхнээ зориулж яваа нэгэн. "Хера холдинг" групп өнөөдөр олон салбар компанитай болж, тэр хэрээр олон мянган хүнийг ажлын байраар хангаж байгаа. Нэг ч гэсэн монгол хүн ажилтай, орлоготой байвал улсын хөгжилд оруулж байгаа хувь нэмэр тэр шүү дээ. Мөн олон жирийн ажилчдын дунд байж, тэдний амьдрал ахуйг тольдож явдаг хүн хүний хөгжлийн цоожинд таарах түлхүүрийг гартаа атгасан л байж таарна. Бидэнд баяжихын төлөө, мөнгөтэй болох гэж УИХ-ын гишүүний суудал руу зүтгэдэг хүн хэрэггүй. Харин улс орныг хөгжүүлэх сэтгэлтэй, баялаг бүтээж чаддаг, жирийн иргэдээ ойлгодог л хүн хэрэгтэй байна.

### Нэр цэвэр, мөр цагаан

Шударга байцгаая. Уг нь бол энэ бидний байгуулах хамгийн гэрэл гэгээтэй нийгмийн зорилт. Харамсалтай нь өнөөдөр улс төрд шударга, нэр цэвэр, мөр цагаан хүн цөөхөн болж. Тэр ч улс төрч ингэж идэж уулаа. Тэдэн сая, тэрбумаар нь зувчуулсан. Гадаадад татваргүй буюу оффшор бүсэд мөнгөө нуусан гээд шударга бусын жишээ ар араасаа цуварсаар. Бид шударга, нэр цэвэр хүн хайх тусам шударга бусчуудын тоо нэмэгдээд байна. Тэгвэл Хассуурийн Ганхуягийг нэр цэвэр гэдэг "сагс" руу хийж болно. Тэр өнгөрсөн хугацаанд өөрийгөө боловсруулж, төлөвшиж, ухаарч, ажлаа хийж, баялаг бүтээж л явсан. Тэгж ч яваа. Ямар ч хар муу бүхэнд холбогдоогүй. Өөрийнхөө ажлыг хийж, сүүлийн 10 жилийн хугацаанд 3000 гаруй хүнийг ажлын байраар хангаж, цагаан мөртэй яваа нэгэн. Бид улстөрчдөө идсэн уусан, нуусан дарсаныг нь гайхаад л суухын оронд шинэ хүмүүсээр солих  цаг болсон.

### Шинэ сонголт Монголын ирээдүй

Бүхий л зүйл шинэчлэгдэж байх ёстой. Тэгж байж илүү сайжирч, өөрчлөгдөнө. Ухаалаг гар утасны бүх аппликейшн хүртэл ойр ойрхон шинэчлэл хийдэг биз дээ. Түүнтэй адил улс төрд хүртэл шинэчлэл хэрэгтэй байна. Сүүлийн 20 гаруй жил улс төрд томоохон салхи сэвэлзэж, өөрчлөлт орсон бил үү. Том том албан тушаалыг нь авдаг хууччуулын армийн гол хүмүүс байсаар л байна. Зарим нь улс төрд туршлага хэрэгтэй гэдэг. Яахав, тийм байж болох л юм. Гэхдээ туршлагыг нь ашиглах хүмүүсийн тоо хэтэрхий ихдээд, олдохоороо өлдөнө гэгч болоод байна. Яг ийм байдлаар эрх баригчид Монгол Улсын эдийн засаг яст мэлхийн хурдаар урагшлуулж байна. Хөгжил дэвшил удах тусмаа л мөхөл рүүгээ хурдтай ойртоно гэж эдийн засагчид хэлдэг. Тэрхүү хөгжил, дэвшлийн "хурдыг нэмэх" эрч хүчтэй шинэ багт багтах  ёстой хүний нэг нь Х.Ганхуяг. Хөгжлийн хурдыг далайцтай, хурдан хугацаанд урагшлуулахад шинэ үеийн залуус л шинэ зүйлийг сэтгэж, хийж, улс орноо хөгжүүлэхийн төлөө зүтгэх цаг нь ирсэн. Монголын ирээдүйг илүү сайхнаар, өөдрөгөөр төсөөлж л байвал бид шинэчлэл хийхийн тулд шинэ сонголт хиймээр байна. Шинэ, залуу, боловсролтой, амьдралын ухаантай, "агаарт хөөрчихөөгүй" хүмүүсийг сонгох цаг болжээ.



**БЛИЦ:**

**Нэр:** Хассуурийн Ганхуяг
**Төрсөн огноо:** 1977 оны 6 сарын 19
**Ам бүл:** Эхнэр, хоёр хүүхдийн хамт амьдардаг
**Төгссөн сургууль:**
1984–1991 онд хуучнаар зөвлөлтийн 9–р дунд сургууль
1991–1994 онд Монгол – Оросын хамтарсан 3–р дунд сургууль төгссөн.
1994–1998 онд МУИС –ийн Олон улсын харилцааны дээд сургуулийг төгссөн.
2013 онд Харвардын Бизнесийн сургууль – Захирлуудад зориулсан бизнесийн удирдлага, ерөнхий менежментээр төгссөн.

**Ажилласан байдал:**
2003 оноос өнөөг хүртэл "Хера Холдинг"–ийн үүсгэн байгуулагч, Захирлуудын зөвлөлийн дарга
2008–2015 он хүртэл "Ремикон" ХК–ийн ТУЗ–ийн дарга, санаачлагч
2010–2014 он Уул уурхайн ассоциацийн удирдах зөвлөлийн гишүүн
2012–2014 он Үйлдвэр хөдөө аж ахуйн сайдын зөвлөх
2010 оноос өнөөг хүртэл Архангай аймгийн Улаанбаатар дахь Тариат сумын нутгийн зөвлөлийн дарга
2015 оноос өнөөг хүртэл Монголын эдийн засгийн форумын /МЭЗФ/ зохион байгуулах комиссийн гишүүн

**Шагнал:**
2011 он "Хөдөлмөрийн хүндэт медаль" шагнал
2013 он "Алтан гадас" одон

*УИХ-ын сонгуулийн 70 дугаар тойрогт бие даан нэр дэвшигч Хассуурийн Ганхуягийн сонгуулийн штаб*

# ШУУРХАЙ МЭДЭЭ


ТОП-МСҮТ

ТОП МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

Элсэлт авах мэргэжлүүд:

-Дууны оператор
-Дүрс бичлэгийн оператор
-Дизайнер, хэвлэлийн
-Дизайнер, орчны
-Нүүр хувиргалт
-Хүний нөөцийн ажилтан

ТОП мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд XXI зууны медиа интертайнмент, дэлгэцийн урлагийн мэргэжилтнүүдийг бэлтгэнэ. Монголын кино, телевиз, театрт дутагдаж байгаа уран бүтээлчдийг Монголын Үндэсний Кино Урлагийн Академи, Дээд гэгээн пикчерс болон бусад студи, продакшны захиалгаар чадвартай мэргэжилтэн бэлтгэж ажлын байраар хангана.

Боловсролын зэрэг: Бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон мэргэжлийн дипломтой төгсөнө
Тэтгэлэг: Суралцах хугацаандаа сар бүр 70.000 төгрөгийн тэтгэлэг авна
Дадлага: Кино, телевиз, театрын салбарт уран бүтээлийн дадлага хийнэ
Ажлын байр: Ажлын байраар 100% хангана
Сургалтын төлбөр: Нэг жилийн төлбөр 500.000₮
Суралцах хугацаа: 2.5 жил

Хаяг: УБ хот, Баянзүрх дүүрэг, Рансар XII хороолол, Их тойруу 57/1
ФАКС: 976-70155585,
ШУУДАН: УБ-49 Ш/Х-806
ИМАЙЛ: enkhjin2007@yahoo.com

Утас:80810890


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Тендер шалгаруулалтын нэр:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлэх түлхүүр гардуулах нөхцөлтэй Хороолол доторх авто замын засвар шинэчлэл /БЗД, 6 дугаар хороо/

**Тендер шалгаруулалтын дугаар:** УБЗАА-16/03

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас эрх бүхий тендерт оролцогчдоос Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлэх түлхүүр гардуулах нөхцөлтэй Хороолол доторх авто замын засвар шинэчлэл /БЗД, 6 дугаар хороо/ гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 50 000 [Тавин мянган] төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

**Нийслэлийн Төрийн сан банк:** 200051008

Тендерийн хамт 1 850 000 [Нэг сая найман зуун тавин мянган] төгрөг, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн, 11 цаг - аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 11 цаг 30 минут - нд нээнэ.

Уг гэрээг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: "тийм" Үүнд: Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна.

**Зам, тээврийн яамнаас олгодог:**
2.8.1. Хатуу хучилттай зам барих
2.8.6. Хатуу болон хайрган хучилттай зам засварлах

**Эсвэл Зам, тээврийн яамнаас олгодог:**
3.7.1.1. ЗБ-1 Хучилттай зам барих
3.7.4.1. ЗЗА-1 Бүх төрлийн замын засварын ажил

Зураг төсөл боловсруулах байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна. Зам, тээврийн яамнаас олгодог:

2.3. Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах

**Эсвэл Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамнаас олгосон:**

2.3 Хотын зам, замын байгууламжийн зураг төсөв боловсруулах

Байгууламжийн зураг, төсөл боловсруулах, барих ажлын гүйцэтгэлийн нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь Сүүлийн 3 жилийн борлуулалтын дундаж орлого нь 100,000,000 /Нэг зуун сая/ төгрөг-с багагүй байх.

Сүүлийн 3 жил буюу 2013, 2014, 2015 онуудын аль нэг жилд дор хаяж нэг удаа ирүүлсэн үнийн саналын 30%-аас доошгүй төгрөгний ижил төстэй ажлын гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байна.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**УЛААНБААТАР ХОТ, ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, БАГА ТОЙРУУ-3, Ц.ЖИГЖИДЖАВЫН ГУДАМЖ-9, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ II БАЙР, ХАНГАРЬД ОРДОН 602 ТООТ, УТАС:31-54-30**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 06 дугаар сарын 14-ны өдөр

**Тендер шалгаруулалтын нэр:** "Гэр хорооллын 10 байршилд нийтийн тээврийн зогсоол барих" ажил

**Тендер шалгаруулалтын дугаар:** БӨ-16-А/12

О**рхон аймаг Баян-Өндөр сумын ЗДТГ** эрх бүхий тендерт оролцогчдоос "Гэр хорооллын 10 байршилд нийтийн тээврийн зогсоол барих" ажлыг гүйцэтгэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 80,000 (наян мянга) төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тушаана.

Төрийн сан

**Дансны дугаар:** 210155402

**Хүлээн авагч:** Баян-Өндөр сум ЗДТГазар нэмэлт санхүүжилт

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын хувьд дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн дундаж борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас доошгүй байна.

Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон зээл авах боломжтой байх.

2014, 2015 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх

Санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй ажлыг сүүлийн 2 жилд гүйцэтгэсэн байх.

**Дараах тусгай зөвшөөрөлтэй байх:** Үүнд: Барилгын ажлын 2.1.1 тусгай зөвшөөрөлтэй байх.

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн 1.0 хувьтэй тэнцэх хэмжээний тендерийн баталгаа гаргаж ирүүлнэ.

Энэ урилгад заагдаагүй бусад нөхцлийг тендерийн баримт бичигт тусгасан болно

Үнийн саналыг 2016 оны 07 дугаар сарын 18-ний өдрийн 10 цаг 00 минутаас -аас өмнө доорхи хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2016 оны 07 дугаар сарын 18-ний өдрийн 11 цаг 00 минутанд Баян-Өндөр сумын "Иргэний таним"-д нээнэ.

**Дотоодын давуу эрх тооцохгүй**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**[ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМ ЗДТГАЗАР 201 ТООТ, УТАС:70358140]**

ХААН БАНК

Цахим банкны аян

# "ЦАХИМ БАНКНЫ АЯН"-Ы ТАВ ДАХЬ ТОХИРЛЫН ЭЗЭД ШАГНАЛАА ГАРДАН АВЛАА

ХААН Банкнаас орон даяар зарласан Цахим банкны урамшуулалт аяны тав дахь тохирлын эздээр тодорсон азтай харилцагчдыг ХААН Банкны удирдлагууд 6-р сарын 15-ны өдөр хүлээн авч талархал илэрхийлэн шагналыг гардуулан өглөө.

Ширээний компьютерийн азтанаар Улаанбаатар хотын харилцагч Д.Золзаяа, Б.Нямдарь нар, Нөүтбүүкний азтанаар Улаанбаатар хотын харилцагч Т.Ариунаа, iPad-ны азтанаар Улаанбаатар хотын харилцагч Б.Байгалмаа, iPhone6s гар утасны азтанаар Төв аймгийн харилцагч С.Энхчимэг, Токио хотод аялах эрхийн азтанаар Улаанбаатар хотын харилцагч П.Амаржаргал тодорч ийнхүү шагналаа гардан авлаа.

Тус аян 6-р сарын 30-ны өдрийг дуустал орон даяар үргэлжлэх бөгөөд 14 хоног тутам цахим банкны 1 төрлөөр дагнан 5 болон түүнээс дээш гүйлгээ хийсэн харилцагчдаас 6 азтай харилцагчийг тодруулах юм. Цахим банкны аяны хамгийн сүүлийн тохирлын эздийг тодруулах шууд нэвтрүүлэг 7-р сарын 3-ны Ням гарагт 19:40 цагаас МҮОНТ-ийн 1-р сувгаар хүрнэ.

Та аяны талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл 131917 дугаарт мессеж илгээж, info.khanbank.com хаягт хандан, эсвэл 1800-1917 дугаарт залгах боломжтой.

Аян дуусахад цөөн хоног үлдсэн тул та бүхэн цахим банкинд амжиж бүртгүүлээрэй. Азтан болох боломж хүн бүрт нээлттэй байна.

АЗТАНУУДЫН СЭТГЭГДЭЛ:



**Компьютерийн азтан Б.Нямдарь:**

*ХААН Банкны "Цахим банкны аян"-ы ширээний компьютерийн азтан болсондоо баяртай байна. Миний хувьд ХААН Банкны харилцагч болсон цагаасаа хойш тууштай үйлчлүүлж, санхүүгийн бүхий л үйлчилгээгээ ХААН Банкаар авч байгаа. Би Мобайл банк, Интернэт банкыг тогтмол ашигладаг. "Та азтан боллоо, танд баяр хүргэе" гээд ярихад эхэндээ итгээгүй. Үнэхээр их баярлаж байна.*



**iPad-ны азтан Б.Байгалмаа:**

*Юуны өмнө iPad-ны азтан болсондоо маш их баяртай байна. Миний хувьд азтан болсоноо ХААН Банкнаас залгаж хэлэхэд анх мэдсэн. Яарсан сандарсан үед Мобайл банк хамгийн хурдан шуурхай, найдвартай байдаг. Тиймээс өдөр тутамдаа Мобайл банкыг ашиглаж, цаг заваа хэмнэдэг. Мөн ХААН Банкны сүүлд нэвтрүүлсэн Экспресс банк хялбар, шуурхай учраас би тогтмол ашиглаж, цаг заваа хэмнэж байна.*



**iPhone 6s гар утасны С.Энхчимэг:**

*Би Төв аймгийн Баянчандмань суманд амьдардаг. Цахим банкны аяны азтан болсондоо маш их баяртай байна. ХААН Банкаар үйлчлүүлээд олон жил болж байна. Миний хувьд Мобайл банкыг ашиглаад iPhone6s утасны азтан болсон. Шагналаа авахаар өнөөдөр өглөө Улаанбаатар хотод ирсэн. ХААН Банкны хамт олонд маш их баярлалаа. Олон хүнийг азтан болгож, баярлуулаарай гэж хэлье.*




**Токио хотод аялах эрхийн азтан П.Амаржаргал:**

*Би хувиараа хүнсний дэлгүүр ажиллуулдаг. Супер азтанаар шалгарч Япон улсад аялах болсондоо маш их баяртай байна. Миний хувьд анх удаа гадаад оронд аялах гэж байгаа болохоор үнэхээр сайхан санагдаж байна. Энэ бол хүн бүрт тохиогоод байхгүй аз учраас их л бэлгэшээж байна даа. ХААН Банкны цахим банкыг ашиглаж азтан болоорой гэж хэлмээр байна.*

Амьдралдаа **их**, банкинд **бага** цаг зарцуулъя!

Харилцагчийн мэдээллийн төв **1800-1917** www.**khanbank**.com khanbank.com/**facebook** khanbank.com/**twitter**

# ЗАВСАРЛАГА


PC mall
БАЯР НААДМЫН
БОДИТ ХЯМДРАЛ
MADE IN TURKEY MADE IN
Elko
32" LED
439,900₮
339,900₮
40" LED
699,900₮
599,900₮
ХАМГИЙН
ДООД ҮНЭ
TORNADO
ХУЙ САЛХИНЫ ТЕХНОЛОГИОР СОРДОГ
ТООС СОРОГЧ
SUPER SALE!
259,000₮
155,400₮
Oishii
ОЛОН ҮЙЛДЭЛТ
УХААЛАГ ЧАНАГЧ
40% OFF
199,000₮
119,400₮
7575-3535
www.pcmall.mn
PCmallOfficial